

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 14
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	15 – 81
1.	<i>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	19 – 42
2.	<i>“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	42 – 50
3.	<i>Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанишагай нарын 21 гишүүн 2026.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	50 – 67
4.	<i>Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>	67 – 81

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 4 дүгээр сарын 08-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Батсуурь, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Б.Түвшин, Г.Тэмүүлэн, Да.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Чойжилсүрэн.

Хэлэлцэж буй асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Энхтүвшин, Р.Батболд, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-

Эрдэнэ, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Ц.Даваасүрэн, Н.Алтанхуяг, Х.Булгантуяа, П.Сайнзориг, Н.Наранбаатар, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Н.Наранбаатар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд, 16
56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 10
Бүгд, 16
37.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 11
Бүгд, 16
31.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, мөн газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга Ч.Чимгэрэл, Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч Ч.Тамираа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Сайнзориг, Ц.Даваасүрэн нар үг хэлж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай тайлбар хийв.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын “4 сарын 01-ний өдрөөс эхлэн” гэснийг “4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд, 15
86.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2026.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналыг хураахын өмнө Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар дэмжигдсэн ажлын хэсгээс гаргасан хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн талаарх саналыг хүчингүй болгох гэсэн санал гаргав.

Н.Наранбаатар: 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “**Хуулийн зорилт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, тус зүйлийн өмнө “**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**” гэсэн агуулгатай **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “аюулгүй байдлыг хангах” гэсний дараа “бодлогын хүрээнд хэрэгжих” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, авто замын түгжрэлийг бууруулах” гэснийг хасаж, мөн зүйлийн “зорилго” гэснийг “зорилт” гэж, “санхүүжилтийн ашиглалтыг” гэснийг “гадаадын зээллэгийн ашиглалтыг” гэж, “зориулан эрх зүйн таатай орчныг” гэснийг “зориулсан эрх зүйн орчныг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, З.Мэндсайхан, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Хосбаяр, Д.Энхтуяа /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “**Хуулийн зорилт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, тус зүйлийн өмнө “**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**” гэсэн агуулгатай **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “аюулгүй байдлыг хангах” гэсний дараа “бодлогын хүрээнд хэрэгжих” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “санхүүжилтийн ашиглалтыг” гэснийг “гадаад зээллэгийн ашиглалтыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд, 15
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд, 15
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хариулж, тайлбар хийв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “**Хуулийн үйлчлэх хүрээ**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “болон гадаад зээллэгийн эх үүсвэрийн урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагатай холбогдсон харилцааг” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “зээллэгийн санхүүжилтийн ашиглалт” гэснийг “зээллэгийн ашиглалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд, 15
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг “2.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг

орон сууцжуулах төсөл.” гэсэн агуулгатай 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд, 15
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“2.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд, 15
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

6.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг “3 дугаар зүйл” болгож, тус зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын зардал**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, НЭГДСЭН ТӨСӨВ ХООРОНДЫН ХАМААРАЛ**” гэсэн агуулгатай **ХОЁРДУГААР БҮЛЭГ**-ийн нэр тус тус нэмж, мөн зүйлийн “нийт зарлага” гэснийг “нийт зарлагын дээд хэмжээ” гэж, “санхүүжилтийн ашиглалтын зардал, түүний зардлын өсөлтөөр” гэснийг “тухайн жилийн ашиглалтын зардлын өсөлтөөр” гэж тус тус өөрчилж, “Тухайн жилийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд, 15
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

7.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 1

Бүгд, 15

93.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал хариулж, тайлбар хийв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 6 дугаар зүйлийг “3.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “гадаад зээлийн санхүүжилтийн” гэснийг “гадаад зээллэгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд, 15

80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 7 дугаар зүйлийг “3.3” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “энэ хуулийн 3.3-т заасан” гэснийг “гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “болон энэ хуулийн 3.1-д заасан хязгаар” гэж нэмж, “санхүүжилтийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд, 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

10.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчилж, мөн зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын ил тод байдал, хяналт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ**” гэсэн агуулгатай **ГУРАВДУГААР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “тухайн жилийн” гэсний дараа “нэгдсэн” гэж тус тус нэмж, “хагас жил тутам” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд, 15
73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

11.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийг “4.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “төслийн ашиглалттай” гэснийг “зээллэгийн ашиглалттай” гэж, “журмын” гэснийг “хууль тогтоомжийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд, 15
73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д “...хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн зүйл бүрээр хэлэлцэнэ.” гэж заасны дагуу төсөлд бусад зүйл гэсэн 4 дүгээр бүлгээр санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: **12.**Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай бүлэг нэмэх:

“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

5.1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т

заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтад 2026 оны төсвийн жилд санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан үйлчлэлд хамруулна.

5.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд, 15
86.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд шинээр нэмэх 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.Дунд хугацаанд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хөгжлийн түнш орнуудын санхүүжилтээр хэрэгжих, төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж болох бөгөөд төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар өрийн баталгаа гаргаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ц.Даваасүрэн, Д.Үүрийнтуяа, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд, 15
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололтой уялдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд, 15
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, **Найруулгын санал:**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зориулан эрх зүйн таатай орчныг” гэснийг “зориулсан эрх зүйн орчныг” гэж, “зорилго” гэснийг “зорилт” гэж, 2 дугаар зүйлийн “Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн” гэснийг “Энэ хуулийн 2.2-т заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн” гэж, “зохицуулах ба энд зааснаас” гэснийг “энэ хуулиар зохицуулах ба энэ хуульд зааснаас” гэж, төслийн 4 дүгээр зүйлийн “үл хамаарна” гэснийг “хамаарахгүй” гэж, төслийн 7 дугаар зүйлийн “санхүүжих зардал” гэснийг “санхүүжүүлэх зарлага” гэж, “нөхцөлд” гэснийг “тохиолдолд” гэж тус тус өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн “төслийн” гэсний өмнөх болон 6 дугаар зүйлийн “нийт” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд, 15
73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод

аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярмагнай, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, “Эрдэнэс Монгол” компанийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Л.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, референт Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Засгийн газраас ирүүлсэн Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Наранбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 08-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
10 цаг 26 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна.

7 дугаар тойрог Нанзадын Наранбаатар ирсэн, 12 дугаар тойрог Жуковын Алдаржавхлан ирсэн, 11 дүгээр тойрог Норовын Алтанхуяг ирсэн, 3 дугаар тойрог Тилеуханы Аубакир ирсэн, жагсаалт Ринчиндоржийн Батболд гишүүн ирсэн, 5 дугаар тойрог Жигжидийн Батжаргал ирсэн, 4 дүгээр тойрог Цэрэнпилийн Даваасүрэн ирсэн, 11 дүгээр тойрог Пүрэвжавын Сайнзориг ирсэн, 2 дугаар тойрог Батжаргалын Заяабал ирсэн, жагсаалт Баатаржавын Мөнхсоёл ирсэн, 2 дугаар тойрог Загджавын Мэндсайхан ирсэн, 11 дүгээр тойрог Чинбатын Номин ирсэн, жагсаалт Даваахүүгийн Пүрэвдаваа ирсэн, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа ирсэн, жагсаалт Дашцэрэнгийн Энхтүвшин ирсэн. Ирцийг танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна. Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026 оны 3 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хоёрдугаарт, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 3 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Гуравдугаарт, Гадаад зээллэгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ.

Дөрөвдүгээрт, Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Н.Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Би нэг горимын санал хэлэх гэсэн юм.

Эрхэм гишүүд ээ, нэг анхаарал хандуулаад өгөөч. Би зарим хурал дээр суух боломжгүй гэдэг нь Үндсэн хууль зөрчсөн ч юм уу, эсвэл байгаа, мөрдөөд явж байгаа Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжтойгоо улайм цайм зөрчилдөх иймэрхүү юмнууд Их Хурал дээр маш их орж ирдэг болсон.

Үндсэн хууль зөрчих гэдгээр би дараа ярья. Манай Байнгын хороон дээр хэлэлцээд бүр анхны хэлэлцүүлэгт зарчмын зөрүүтэй санал гаргачхаад байгаа манай Н.Алтаншагай нарын гишүүдийн өргөн барьсан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хуулийн төслийн тухай ярих гээд байгаа юм.

Би энэ дээр Н.Алтанхуягийн байр суурь гэхээсээ илүүтэй Их Хурлын дэргэд байдаг “Төсвийн тогтвортой байдлын зөвлөл” гэж байдаг.

Бид үүнийг байнга сонсож явах ёстой. Энэ мэргэжлийн зөвлөлийг. Орон тоогоор ажилладаг. Тэгээд тэд нар маань энэ хууль дээр бас дүн шинжилгээ хийгээд, Их Хурлын гишүүдэд цаас тараасан байна лээ. Би тэрнийг үзсэн юм.

Энэ хууль дээр бичээд байгаа юм нь гоё нэртэй байхгүй юу. “Гадаад зээлийн ашиглалт”, тэгээд “үр ашгийг нь нэмэгдүүлнэ” гэж. Яг фактический тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал, дүгнэлтийг үзэх юм бол одоо энэ өргөн барьсан хууль янз бүрийн байдлаар ороод батлагдахад –

- манай төсвийн бүх тоонууд гүйнэ,
- гадаад зээлийн ашиглалт нэмэгдэнэ,
- гадаад зээлийн хүүгийн дарамт нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ бидний баталсан бүх юмыг зөрчсөн ийм хуулийг хойноос нь Их Хурлын хэдэн гишүүн өргөн бариад явдаг бол буруу.

Хоёрдугаарт, ийм том төсөвтэй холбоотой асуудлыг Их Хурлын гишүүд санаачилж бас болохгүй.

Би нэг муу ёртой нэг жишээ хэлье. Энэ яг тийм юманд хүргэнэ шүү. Намайг Ерөнхий сайд байхад Улсын Их Хурлын хэдэн гишүүн санаачлаад Прокурорын дэргэдэх мөрдөнг татан буулгасан. Засгийн газар биш Их Хурал Их Хурлын хэдэн гишүүд.

Тэр хууль батлагдангуут Монголын хууль хяналтын байгууллагын тогтолцоо бүрэн эвдэрсэн. Одоо өнөөдөр хүртэл хууль хяналтын байгууллагын хэн нэгэн этгээд хэн нэгнийг хэлмэгдүүлэхэд тэр хариуцлага хүлээх тэр юмыг алга болгосон. Одоо энэ яг тийм болох вий дээ.

Тийм учраас Н.Наранбаатар дарга та нар маань яадаг юм мэдэхгүй байна. Би бол горимын санал хэлж байгаа юм. Ингээд Үндсэн хууль зөрчсөн. Энэ Үндсэн хууль зөрчөөгүй л байх л даа. Тэгээд энэ өмнөх хуулиудтайгаа улайм цайм зөрчилдсөн.

Бидний арай хийж баахан юм болж байж батлаад гаргасан бүх тоог эвддэг. Тэгээд гадаадын зээлийн үр ашгийг нэмэгдүүлдэг биш, гадаадын зээлийн үр ашиг нэмэгдэх биш бүр харин бид нарыг дампууруулах гадаадын зээлийн нөлөө, харьяанд оруулах гээд байгаа ийм хуулийг хэлэлцээд явчхаж болж байгаа юм уу.

Би ийм горимын санал хэлж байгаа юм. Яадаг юм би мэдэхгүй байна. Дүрэм журам нь. Санал хураадаг юм уу. Та нар маань нэг бодож үзээч ээ. Би маш олон асуудал дээр хэлмээр байх юм. Зарим үед хэлэхгүй хаячих юм. Тэгээд ийм зөрчилтэй байдал үүсээд байна.

Тэгээд бид дараа нь төсөв ярина шүү дээ.

Тэгэхээр бүх юм эвдэрсэн сууж байх.

Н.Наранбаатар: Ингэж байгаа юм. Таны горимын санал хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн.

Тэгэхээр дэгийн тухай хуульд ингэж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 4.1.3-д горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг хэлнэ гээд. Тийм.

Тэгээд энэ асуудлыг болохоор Байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, чуулганаар хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн. Тэгээд даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэх асуудлын тов дараалалд ороод баталсан. Тэгээд ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр хойшлуулах боломж байхгүй гэж ойлгож байгаа.

Тэгвэл горимын саналыг хураах ёстой юу? Тийм. Хэлэлцэх асуудал нь хэлэлцэх асуудлын дарааллын гуравт явж байгаа юм. Тэгээд нэгэнт энд батлагдсан. Ажлын хэсгийн ахлагч нь хэлэлцэх асуудал эхлэхээр зэрэг орж ирнэ. Ажлын хэсгийн ахлагчийн юуг сонсьё.

Энэ асуудал чинь түрүүчийн Байнгын хороогоор бас хойшлуулсан юм. Хойшлоод дахиад орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг энэ асуудлыг хэлэлцээд эхлэхээр зэрэг Та саналаа гаргачих. Тэгэх үү? Н.Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Надад маргаад суугаад байх сонирхол бүр байхгүй болсон л доо. Их Хурал дээр.

Зүгээр энэ буруу яввал тэгээд улсад хохиролтой тусна гэж л би хэлж байгаа юм. Нэг кэйс би хэлье. Н.Наранбаатар дарга аа. Одоо манай Байнгын хороон дээр. Дараа нь ярих үед гээд ингээд хаяна.

Тэгэхээр нэг кэйс хэлье. Энэ Их Хурал зөвхөн одоо ч биш л дээ. Янз янзын үед ийм их замбараагүй зөрчсөн юм хийдэг. Анхны хэлэлцүүлэг хийсэн. Намын бүлгүүд дэмжсэн, Байнгын хороо дэмжсэн тийм төсөл бас өмнө нь явж байгаад. Миний санаачилсан төсөл.

Тэгээд Их Хурлаар орж хэлэлцүүлэх гэхэд нь Их Хурлын дарга нь аваад ширээн доогуур хийгээд ингээд хаясан ч тохиолдол бас байгаа л даа.

Тэгэхээр би хэлэлцэх эсэх биш зарчмын зөрүүтэй саналаар санал хураагаад явах гээд байна л даа.

Тэгэхээр одоо би юмаа зөөлрүүлбэл дахиад та нар маань нэг удаа хойшлуулж болохгүй юм уу? Ер нь бол ийм шүү дээ. Хэрвээ бид ойлголцоод явбал үүнийг өргөн барьсан хууль санаачлагч ямар ч үе шатаас нь юмаа татаж авч болдог байхгүй юу.

Тэгэхээр юмаа яриад ойлголцоод явчхаж болохгүй юм уу? Сангийн яамныхан орж ирээд суусан байдаг. Өмнө баахан нь оруулж ирж батлуулсан хамаг тоогоо ингээд Их Хурлын хэдэн гишүүдээр хуулийн төсөл өргөн бариулаад эвдүүлээд явж болох юм уу?

Цаана нь 3 төсөл гээд байгаа юм. Тэр 3 төслөөр зогсохгүй л дээ. Нөгөө газрын тосны төсөл, энэ Сэлбэ төсөл. Нэг нь юу байлаа. Эрдэнэбүрэн. Тийм.

Энэ чинь төсвөө баталчхаад хойноос нь ингэдэг юм. Хөөш. Б.Заяабал аа, чи бас татвар гээд сууж байсан. Та нар энэ бүлэг дээрээ ярь л даа. Би одоо тэр нам, энэ нам гэхгүй. Энэ улс чинь ингээд болохгүй шүү дээ. Ийм юм хийгээд яваад байхаар чинь. Энд би хажууд нь суугаад юм ярих гэхээр хорлон сүйтгэх үйл

ажиллагаанд оролцсон этгээд болон хувирах гээд. Би тэгээд зарим хуралд чинь суухгүй байгаа шүү.

Одоо хэрвээ үүнийг хэлэлцэнэ гэвэл би суухгүй.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн ээ, ийм юм байна. Дэгийн тухай хуулийн 13.3-д ингэсэн юм байна. Хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч гээд. Эхэлсэн боловч гэж байгаа юм. Түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаанд даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ гээд.

Тэгэхээр эхлүүлээд, тэгээд ажлын хэсгийн байр суурийг сонсоод та горимын саналаа гаргаад санал хураалга. Тэгэх үү? Ингээд явъя. Тийм. Хуулийн гаргалгаа нь ийм юм байна. Зохицуулалт нь.

Тэгээд нэгдүгээр асуудалдаа оръё.

**Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар
2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026 оны 3 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Д.Сайханчулуун Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга, Баяраагийн Урьболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Б.Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Эрдэнэсайханы Билэгт Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулна.

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгөөрэй.

П.Сайнзориг: Баярлалаа. Өглөөний мэнд хүргэе бүгдэд нь.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинаа цахим спортын төрөл маш хурдацтай хөгжиж, зах зээлийн нэгэн томоохон орон зай бий боллоо.

Энэ төрлийн спорт нь 1970-1980 онд видео тоглоом гарч эхэлсэн үеэс эхлэн өнөөдрийг хүртэл хөгжихдөө дэлхий даяар мэргэжлийн лигүүд байгуулагдаж, үзэгч, дэмжигчдийн тоо олон саяар хэмжигдэж, шагналын сан ч гэсэн энэ хэмжээгээрээ өсөж, мөн 2002 онд Азийн наадмын спортын хөтөлбөрт хүртэл багтсан байдаг.

Түүнчлэн энэ спортыг дагаад sponsorship-ийн асуудал явж байдаг учраас амжилттай байх тусам томоохон компаниудын хөрөнгө оруулж, ивээн тэтгэх, хамтран ажиллах олон боломжуудыг эрэлхийлж байдаг.

Нөгөө талаас sponsorship, цалин, streaming, хандив, нэмэлт орлого, рекламн орлого, шагналын сан зэрэг мэргэжлийн тамирчдын хувьд орлогын олон эх үүсвэрүүд байдаг боловч манай улсад энэ боломжууд одоогоор бүрэн утгаараа ажиллаж чадахгүй байгаа учраас тамирчид гадаадын тамирчдын адил боломжийг эдлэх боломжгүй байна.

Нөгөөтээгүүр Биеийн тамир, спортын тухай хуулиар Монгол Улсын Их Хурал биеийн тамир спортыг дэмжих чиглэлийн бодлогыг тодорхойлсон бөгөөд мөн татварын хууль эрх зүйн орчноор уг асуудлыг дэмжиж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаанд хамааралгүй боловч зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэлд тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөхөөр заасан бөгөөд үүнд спортын барилга, байгууламж барих, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монгол Үндэсний олимпийн хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарч байна.

Шинэ тутамд эрчимтэй хөгжиж байгаа ирээдүйд амжилт үзүүлэх боломжтой гэж үзэж болох е-спортын төрөл нь цаашид дэлхий нийтэд хурдацтай хөгжиж байгаа бөгөөд аливаа салбарыг, ялангуяа спортын аль нэг төрлийг хөгжүүлэхэд зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт бус татварын бодлогоор дэмжих нь чухал гэж үзэж энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Энэ хуулийн төсөлд Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасан Үндэсний шигшээ баг байгуулсан. Баг, түүний харьяалагддаг спорт холбоог

хамруулснаар e-sport болон бусад спортын төрлүүд хөгжих, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хүрээнд, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг л нээж өгнө.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Биеийн тамир, спортын тухай хуулын дагуу бүртгүүлсэн e-sport-ын Үндэсний шигшээ баг түүнд бүртгэлтэй тамирчдад олгосон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн шагналын асуудлыг Хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх агуулгыг анхлан санаачилсан боловч хуулийн төслийг гүйцээн боловсруулахдаа уг асуудлыг хассан болохыг хэлье.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Наранбаатар: П.Сайнзориг гишүүнд баярлалаа.

Хуулийн төслийн танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Р.Батболд гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая.

Манай П.Сайнзориг гишүүний хувьд хамтраад тодорхой хуулийн төсөл санаачилж, үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж байна.

Тэгэхээр өмнө нь бид энэ спортын арга хэмжээг дэмжих үүднээс Аж ахуйн нэгжийн орлогын 1 хувьтай тэнцэх татварын энэ эрхийг нээсэн.

Тэгэхээр таны энэ саяын боловсруулж орж ирж байгаа хууль энэ хууль дотроо нэрийг нь оруулвал болохгүй байх байсан уу гэж. Би тэгж ойлгоод байгаа байхгүй юу.

Ер нь байж болох хэмжээ нь нэг юм байна. Тэр дотроо тухайлсан өргөтгөлүүд хийвэл тэр хууль дотроо нэрийн өргөтгөл хийх замаар явбал зохистой бодлогын нэгдмэл нь хангагдах юм биш үү? Тус тусдаа хэдүүлээ тодорхой чиглэлүүдээр хууль гаргаад байхаар өнөө нэг маань өөрөөр ойлгогдоод явах вий дээ гэсэн ийм надад нэг тийм санаа байгаад байгаа юм. үүнийг бид бодох ёстой гэж.

Энэ дээр таны байр суурь, хуулийн төслийг боловсруулж байх явцад хийсэн судалгаа, тооцооллоор чинь ер нь ямархуу зүйл гарч ирж байна вэ гэж. Нэг.

Хоёрдугаарт, ер нь баялаг бүтээгчдийг дэмжье гэдэг үүднээс татварын багц хуульд нэлээн томоохон өөрчлөлт оруулах санал юмнууд орж ирээд, нийлбэр дүнгээр нь төсөл өргөн баригчийн гаргаж ирсэн тооцооллоор 2.7 их наядын татварын ачаалал буурах юм байна гэж тооцоолол хийсэн. Тэр Хувь хүний орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар гээд тооцохоор.

Гэхдээ наад нэр дурдагдаад байгаа татварууд бүгд орон нутгийн төсөв дээр харьяалалтай. Тэр түвшинд ордог.

Тэгэхээр энэ орлогыг бид чөлөөлөлт өгөхөөр зэрэг орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдэх, эсвэл орон нутгийн төсвөөс улсын төсөв рүү төвлөрүүлэх орлогын хэмжээ буурах энэ ачаалал талаасаа харах юм бол бараг 4 их наяд руу дөхөх болов уу гэсэн тооцоолол гарч ирээд байгаа юм.

Энэ дээр манай Сангийн яам, татварын байгууллага ер нь ямархуу байдлаар дүгнэлт хийж явж байгаа вэ?

Одоо бид хэд энэ дэлхий нийтийг хамарсан хямралт байдал, тэр тусмаа газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тодорхой хурдцыг нь хязгаарлахын тулд тодорхой арга хэмжээнүүд авъя гээд үүний ар дээр тодорхой тогтоол орж ирж... /минут дуусав/

Н.Наранбаатар: Ж.Батжаргал гишүүн гүйцээж асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ хүрээнд ер нь хэдий хэмжээний төсөвт төвлөрөх орлогыг чөлөөлөхөөр –

— Та хэд тооцоолол юмнуудаа хийж байгаа вэ?

— Энэ ер нь улсын төсөв, орлого талд ер нь ямар хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгох вэ?

— Ийм тооцоолол хийсэн зүйл байна уу?

Сангийн яам, татварын байгууллага. Энэ талаас нь нэгдсэн бодлого, цонхоор харж, нэгдсэн дүгнэлт хийхгүй бол боломгүй юм уу гэсэн санаа байгаад байх юм.

Ийм хоёр асуултад хариулт авъя.

Н.Наранбаатар: Эхлээд П.Сайнзориг гишүүн, дараа нь татварынхан, Сангийн яамныхан хариулна. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ж.Батжаргал даргын асуултад баярлалаа.

Би ерөөсөө л Тантай яг адилхан зарчим, нэг зохицуулалт буюу нэгдмэл бодлогоор л явж байгаа.

Улсын Их Хурлаас баталж өгсөн спортыг дэмжих төрийн бодлого нь татварын бодлогоор дэмжиж байгаа. Энд аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн орлогын 1 хувийг зарцуулах боломжийг нээж өгсөн.

Энэ дээр тодорхой хүрээг нь тогтоогоод өгсөн. Үндэсний олимпын хорооны гишүүн, эсвэл паралимпын хорооны гишүүн, эсвэл олимпын төрлийн спорт. Энэ төрлийн спорт, холбоодын баг, тамирчин, дасгалжуулагч, эсвэл энэ төрлийн спортыг зохион байгуулах, эсвэл барилга, байгууламжийг барихад энэ хөрөнгөө зарцуул гэсэн.

Энд хараахан Засгийн газрын гишүүн болох Спортын сайдын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу байгуулагдсан бусад Үндэсний шигшээ багууд хамрагдахгүй байгаа. Олимпын төрлийн бус. Энд маш цөөхөн Үндэсний шигшээ багууд хамрагдахгүй үлдээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр л хамруулж өгч байгаа. Ингэж хамруулж өгч байгаа нь яг тантай адилхан илүү өөр зохицуулалтыг бий болгох гээд байгаа зүйл биш. Энэ нь аж ахуйн нэгж, байгууллагын боломж дээр e-sport болон бусад тэр Үндэсний шигшээ багийг хамруулаад өгье гэж нэгдүгээрт бодлого нь энэ байгаа.

Хоёрдугаарт, энэ хууль өөрөө яг хүчин төгөлдөр хууль буюу аж ахуйн нэгж, байгууллага 1 хувиа зарцуулж байгаа учраас ямар нэгэн байдлаар төсвийн орлого дээр бууруулах гэдэг юм уу, төсөвт ачаалал өгөх зүйл байхгүй.

Би хууль боловсруулах ажлаа гүйцээн боловсруулахдаа хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдүүлье. Ийм байдлаар явахад ямар нэгэн асуудал гарахгүй. Одоо явж байгаа 1 хувь нь хэвээрээ учраас энэ дээр угаасаа төсөвт дээш, доош гүйх ч гэдэг юм уу, тоон агуулгаараа ямар нэгэн ачаалал, дарамт, төсвийн орлого бууруулалт дээр нөлөөлөхгүй гэдэг зүйлийг танд хэлье.

Бусад зүйлийг нь Сангийн яам. Яах вэ, миний хуультай том том асуудлууд яригдаж байна. Энэ хууль 4 их наяд дээр хөнгөлөх, чөлөөлөх юм байхгүй шүү. Зөвхөн спортын асуудал байж байгаа. Тийм.

Н.Наранбаатар: Индрийн микрофоныг өгье. Сангийн яам. Нэр, албан тушаалаа хэлье.

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

025 оны 12 сарын 30-нд барьсан Татварын багц хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар Татварын хуулийн шинэчлэлийн асуудлуудаа эргүүлэн татаж авсан.

Энэ бол олон улсын эдийн засгийн нөхцөл байдлуудтай холбогдуулаад, мөн шинэ Засгийн газрын бодлого, чиглэлтэй уялдуулаад татварын асуудлуудаа эргэж харж эрэмбэлэх шаардлага байсан учраас хуулиа татаж авсан.

Ер нь өргөн барьсан хуульд татварын шууд нөлөөлөл нь 2.7 их наядын нөлөөлөлтэй хуулийн төслийг өргөн барьсан байсан. Үүнийг татаж авсан байгаа.

П.Сайнзориг гишүүний санаачилж байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.9 дээр Сангийн яам өмнө нь саналаа өгөхдөө тухайлан хуульд спортын төрлийг оруулахыг дэмжээгүй. Харин Засгийн газрын тийм тусгай санд энэ 22-ын... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулъя. Индрийн микрофоныг.

Ч.Чимидсүрэн: 22.9.10 дээр Засгийн газрын тусгай санд дэмжлэг үзүүлэх, хандив дэмжлэг үзүүлэх боломж нь нээлттэй.

Засгийн газрын тусгай сандаа спортыг дэмжих сангаар нь дамжуулаад ямар төрлийн спорт байна, дэмжих боломж нь бололцоотой, хуулийн гаргалгаа байна гэж хариуг бид өгч байсан.

Энэ хууль 2024 оны 8 сарын 30-нд батлагдаад үндсэндээ 2025 оны 5 сард яамд журмаа баталснаар 2025 оноос үндсэндээ эрх зүйн хувьд хэрэгжих боломж нь гарсан.

Тэгээд 2025 оны дүн мэдээгээр нийт 304 аж ахуйн нэгжийн 103 тэрбумын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлан мэдээ нь татварын албан дээр ирсэн байна. Одоо энэ дээр нь төсөл болгоноор нь хийгээд баталгаажуулах ажил нь татварын албан дээр хийгдэж байна.

Н.Наранбаатар: Ж.Батжаргал гишүүн тодруулъя. Гүйцээгээд хариулъя.

Ч.Чимидсүрэн: Гадаад нөхцөл байдалтай холбогдуулаад шатахуунтай холбоотой АИ92, мөн дизель түлштэй холбоотой гаалийн татварыг тэглэх тухай асуудал хэлэлцэгдээд Улсын Их Хурлын тогтоол гарахаар хэлэлцэх эсэх асуудлыг нь шийдвэрлэсэн байгаа.

Энд хэрэв он дуустал бид гаалийн татварыг тэглэх юм бол 300 тэрбумын нөлөөлөлтэй байгаа. Ийм тооцоо нь гарсан байгаа.

Н.Наранбаатар: Болсон уу? Д.Энхтүвшин асуулт асууя.

Д.Энхтүвшин: Энэ хууль дээр 3 хууль оруулж ирж байгаа юм байна. Тэгээд тус бүрдээ татварын хөнгөлөлттэй холбоотой харилцаанууд.

Нэгдүгээрх нь, татварын 1 хувийн хөнгөлөлттэй холбоотой заалт дээр Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн Үндэсний шигшээ багийн хэрэгцээнд гээд.

Яах вэ, П.Сайнзориг гишүүний саяын танилцуулгад болохоор e-sport гэж ярьж байна. Гэхдээ яг энэ тодорхойлолтыг нь аваад үзэхээр улсын төсөв болон спортыг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх спортын төрөл, ангиллыг сонгох, Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх гэдэг заалт байна л даа. 10.1.1 нь.

Өөрөөр хэлбэл эхний асуулт нь 1 хувийн заалтыг оруулж ирснээр –

- Олимпын хэдэн төрлийн холбоо байдаг юм?
- Олимпын бус нь хэдэн төрлийн холбоо болдог юм?
- Хичнээн тамирчидтай холбоотой асуудал байдаг юм?

Нэгд ийм мэдээлэл өгөөч.

Хамрагдаж байгаа хүрээ нь яаж өөрчлөгдөж байгаа гэдэг талаар нэг мэдээлэл.

Хоёрдугаарт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасан шигшээ багийн бүрэлдэхүүнд зориулсан, түүний хэрэгцээнд зориулсан гадаад улсын иргэн, хуулийн этгээдээс буцалтгүй тусламж, хандиваар өгсөн зүйлүүдийг гаалийн татвараас хөнгөлөх, тэгээд НӨАТ-аас хөнгөлөх гэсэн ийм 2 хуулийн заалт орж ирж байгаа юм байна.

Өөрөөр хэлбэл ерөнхийд нь л спорттой холбоотой харилцаанууд дээр татварын хөнгөлөлт үзүүлье гэдэг асуудал орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр Гаалийн ерөнхий газар, гааль болон НӨАТ дээр хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудлуудыг нэмээд яваад байхад ямар бодлого барьж байгаа юм? Энэ нь Сангийн яам, Татварын ерөнхий газар дээр бодлого нь хэрэгжиж, ийм зарчмаар явахад болж байгаа юм уу? Энэ талаар нэг тайлбар өгөөч.

Гуравдугаарт, шууд өргөн барьсан төсөлтэй холбоогүй. Тэгэхдээ 1 хувийн татвартай холбоотой хуулийн заалтыг бид байгууллагуудыг нийгмийн шинжтэй төслүүдийг, энэ тохиолдолд спортыг дэмжье гээд оруулсан боловч яг үнэндээ хэрэгжилт хангалтгүй байгаад байна. Тэр хэрэгжилтийн талаар холбогдох газрууд байвал мэдээлэл өгөөч.

Ер нь зарим яамд дүрэм, журмуудаа гаргасан байгаа юм. Гэтэл зарим юунууд ерөөсөө дүрэм журам гаргахгүй байна. Гаргасан ч гэсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээж авахгүй байна. Тухайлбал, 22.9.8 дээр судалгаа, шинжилгээний зориулалтаар олгох тэтгэлгүүдийг энэ 1 хувийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулахаар оруулсан боловч үүнтэй холбоотой дүрэм, журам нь ерөөсөө гарахгүй байна. Шадар сайдын харьяанд байдаг боловч яг энэ талаар ямар өөрчлөлт ахиц гарч байгаа вэ? Энэ хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөөч? Баярлалаа.

Н.Наранбаатар: Эхлээд П.Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Би эхлээд хариулаад, дараа нь манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас, тэгээд Сангийн яамнаас хариулаад өгөөч ээ гэж хүсэж байна.

Хамрагдах хүрээн дээр олимпын болон олимпын бус, паралимпын, үндэсний олимпын хорооны гишүүн холбоод байгаа.

Энэ дээр Үндэсний шигшээ баг байгуулсан олимпын төрлийн бус цөөн холбоодууд байгаа. Энэ дээр яг тоог нь хэлчих. Үндсэндээ e-sport-ийн чиглэлээр Үндэсний шигшээ баг бүрдүүлсэн байдаг. Үндэсний шигшээ баг бүрдүүлээд эхний цалин хөлс олгосон тохиолдлууд гарсан юм билээ.

Тэгээд залуучууд энэ цалин хөлснөөсөө татгалзсан. Олон нийт хүлээж аваагүй. Ийм хэл амтай зүйл байгаа гэдэг үүднээс цаашдаа энэ цалин хөлсийг авахгүй гэдэг зүйлийг ч гэсэн сошиал эрч сошиалд мэдэгдэл гаргаж хэлсэн байна лээ.

Гол асуудал юу вэ гэхээр түрүүн Сангийн яамны дарга буруу хэллээ. Энэ e-sport-ийг төсвөөс гаргаж мөнгө өгөх гээд байгаа зүйл ерөөсөө биш байхгүй юу. Энэ аж ахуйн нэгж, байгууллага чинь өөрийн орлогын 1 хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд спортыг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байгаа энэ хүрээнд л e-sport болон бусад олимпын төрлийн бус Үндэсний шигшээ баг бүрдүүлсэн багуудыг хамруулъя гэж байгаа болохоос биш тэр Засгийн газрын тусгай сангаас дэмжих гээд байгаа зүйл ерөөсөө байхгүй.

Тийм учраас энэ хүрээнд e-sport шийдэгдэх ч боломжгүй. Энэ өөрөө эргээд тоглолтын гэдэг юм уу, энэ спортын онцлог нь нэлээн тренд болж байгаагаас гадна маркетинг болоод манай аж ахуйн нэгж, байгууллагууд хамтраад ажиллах юм бол бараа, үйлчилгээгээ олон улсын зах зээл дээр хүргэх том боломж байгаа.

Яг үнэндээ хэлэхэд яг энэ төрлийн багууд чинь манайдаа хууль бусаар гэж тооцогдоод байгаа тэр “1xBet” компаниудын ивээн тэтгэлгээр явж байсан байхгүй юу. Үүнийг нь нэгэнт бид хэд хязгаарлаад өгч байгаа учраас цааш цаашдаа дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах тэр бололцоог нь

зүгээр аж ахуйн нэгж, байгууллага боломж олгож байгаа болохоос биш төсвөөс нэг төгрөг ч гаргаж өгөх гээд байгаа зүйл байхгүй юм.

Тэгэхээр Сангийн яам энэ дээрээ хариултуудаа зөв хэлээсэй гэж хүсэж байна.

Гаалийн тариф болон гаалийн албан татвар, НӨАТ-аас спортын Үндэсний шигшээ багт бусад гадаад улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өгч байгаа тоног төхөөрөмжийг чөлөөлөх асуудлыг оруулж өгч байгаа нь ерөөсөө л хүүхэд, залуучуудын хөгжлийн төлөө л хийж байгаа юм. Энэ дээрэлхэлт, энэ цагаа боловсон өнгөрүүлэх.

Яг үнэндээ хэлэхэд спорт холбоод чинь санхүүгийн хувьд бүрэн бэхжээгүй байдаг юм билээ. Үнэгүй хандив тусламж өгөөд байхад тэрийгээ төлөөд гааль, НӨАТ-ыг нь төлөөд авах бололцоо байхгүй. Заримыг нь гааль дээр ч юм уу хаяад орхих тохиолдлууд ч зөндөө байгаа. Үүнийг нэг тоог нь хэлээч.

Тэгэхээр энэ асуудлыг хүүхэд, залуучуудаасаа буюу спорт гэдэг чинь хүүхэд, залуучуудын тухай л асуудал шүү дээ. Энэ зөөлөн хүчний бодлогын асуудал. Спортоор дамжуулж Монгол Улсын нэр хүндийг өргөх энэ асуудал дээр төсвийн орлого бүрдүүлэлт гэж харахаасаа илүүтэй хүүхэд, залуучуудын цаашдын хөгжилд оруулж байгаа ийм зүйл юм гэдэг зүйлээс л харах хэрэгтэй юм болов уу гэж үүднээс үүнийг явсан.

Тэгээд яг тоог Соёл, спортын яам болон Сангийн яамнаас хэлээдхээч ээ.

Н.Наранбаатар: Мэргэжлийн яам. Индрийн микрофон. Нэр албан тушаалаа хэлээд хариулна шүү.

Б.Бат-Эрдэнэ: Сайн байцаана уу? Эрхэм Байнгын хороон дарга болон Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Соёл, спорт, аялал жуучлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ.

Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх баг бүрэлдэхүүнд 26 баг бүрэлдэхүүнээс e-sport-ийн төрөл байгаа.

Мөн олимпын бус төрөлд нь шатар болон e-sport-ийн төрөл хамрагддаг.

Н.Наранбаатар: Сангийн яам. Индрийн микрофон өгье.

Ч.Чимидсүрэн: Түрүүний асуултад ойлгомжгүй хариулсан юм шиг байна.

Засгийн газрын тусгай санд гэдэг нь төсвөөс өгөх гээд байгаа зүйл биш. Тухайлан энэ хууль дээр тэр e-sport буюу тэр шигшээ багийг яахгүйгээр тэр хандив тусламжийг нь тухайн байгууллага өгч байгаа бол Засгийн газрын тусгай санд тэр спортыг дэмжих санд нь өгөх юм бол тэр зориулалтаараа зарцуулагдах хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүйгээр одоо байгаа хуулиараа зохицуулагдах боломжтой байна гэж байгаа юм.

Тэр нь аж ахуйн нэгж, байгууллага дэмжлэг үзүүлэх, хандив өгөх, Засгийн газрын санд орох эрх нь нээлттэй байгааг уг нь тайлбарласан юм.

Гааль, тарифын тухай хууль дээр 38 дугаар зүйлд нь энэ спорттой холбоотой тоног төхөөрөмж болон хил гаалиар орохтой зүйлийг гаалийн татвараас чөлөөлөх заалт нь хүчинтэй байгаа. Тэр жагсаалт нь Засгийн газар батлаад явдаг.

Тэгэхээр үүнийг давхардуулан хуульчлах шаардлагагүй гэдгийг хэлж байгаа.

НӨАТ-ын хувьд гаднаас орж ирж байгаа тэр тоног төхөөрөмж, тэр хандивлагчдын хандиваар орсон уу, үгүй юу гэдгийг нь тодорхойлох тэр боломж... /минут дуусав/

Н.Наранбаатар: Д.Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Энэ олимпын бус төрлийн холбоо гэхээр 2 л холбоо байгаа юм байна. Тийм ээ. Шатар болон e-sport.

Тэгэхдээ шигшээ баг бүрдүүлсэн гэдэг агуулгаар 2 байгаа юм байна. Цаашдаа энэ нь өргөжих бололцоонууд заалтаараа дагагдаад жишээлбэл тэр хөнгөлөлтийн заалтууд нь бусад холбоонуудаас нэмэгдэх тийм бололцоо гарах юм байна гэж харлаа.

Тэгээд хөнгөлөлттэй холбоотой асуудлууд дээр гаалийн. Сая хэлэхдээ Ч.Чимидсүрэн Сангийн яамнаас хэлэхдээ хуулийн хөнгөлөлтийн заалт нь байгаа учраас дахиж нэмэх шаардлагагүй юм гэсэн асуудал ярьж байна. Үүнийг тодруулаад өгөөч?

Н.Наранбаатар: Индрийн микрофон. Сангийн яам.

Ч.Чимидсүрэн: Гааль тарифын тухай хуулийн 38.1.19-д заасны дагуу спортын зориулалттай тоног төхөөрөмж, хэрэглэлийг гаалийн татвараас чөлөөлж байгаа. Ийм хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт байдаг.

Тэгэхээр энэ дээр дахин нарийвчлан зохицуулах шаардлагагүй. Энэ заалтаараа явах боломжтой гэж үзэж байгаа.

НӨАТ-ын хувьд аягүй түвэгтэй байдал үүсэхээр байгаа. Өөрөөр хэлбэл цаанаас хандивлаж байгаа зүйлс нь яг хандивынх уу, үгүй юу гэх мэтчилэн хэрэглээ талдаа нэлээн түвэгтэй байгаа учраас үүнийг шийдвэрлэхэд түвэгтэй гэж үзээд байгаа юм, бид.

Н.Наранбаатар: Р.Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Ерөнхийдөө асуулт давхардаад байна.

Тэр 1 хувьтай холбоотой. Тэнд оруулж болохгүй байсан юм уу гэдэг.

Засгийн газрын тэмдэглэлээс нь харах юм бол засаг нэг их айхтар дэмжээгүй юм шиг харагдаад байна.

Д.Энхтүвшин гишүүний асуугаад байгаа л тэр л дээ. Яг Үндэсний шигшээ баг гэж испортын Үндэсний шигшээ баг гэж байгаа юм уу, үгүй юу гэдэг. Тэгээд тэр нь одоо энэ татвараас асуух юм бол хэчнээн төгрөгийн тоног төхөөрөмж оруулж ирээд яг Үндэсний шигшээ багтаа гэдэг юм уу, үүнийг чөлөөлж өгөөч гэсэн ийм хүсэлт байдаг юм уу, байхгүй юм уу?

Ер нь орж ирсэн бол хэчнээн төгрөгийн татвар төлөөд байна? Яах вэ, зөвхөн e-sport гэлгүйгээр нийтийн биеийн тамир спорт руу чиглүүлсэн зүгээр байсан юм уу гэдэг нэг зүйл байгаад байна. Энэ хоёроор хариулт авчхаад тодруулах зүйл байвал тодруулъя.

Н.Наранбаатар: П.Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Гишүүддээ хэлэхэд яг энэ 1 хувьдаа л хамрагдаж байгаа.

1 хувь буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэг байхгүй юу. Энэ 22.9-д ямар зүйлүүдийг оруулж байна гэдэг нь спортын асуудал нь 22.9.6 дээрээ тодорхой байж байгаа.

— Спортын байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах,

— Монголын үндэсний олимпын баг, хороо,

— Монголын үндэсний паралимпын бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон –

-санхүүгийн дэмжлэгийг энэ 1 хувьд хамааруулж хөнгөлнө шүү гэдэг заалт дээр нэмээд Спортын сайдын, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр байгуулагдсан Үндэсний шигшээ багийг л хамруулж байгаа.

Энэ дээр тооны хувьд өнөөдөр 2 л байна. Бодлогын хүрээнд тэргүүлэх ямар чиглэл гэж харж байгаа. Энэ хүрээндээ угаасаа e-sport орж байгаа, шатар л байгаа. Тоог нь цаашдаа хязгаарлах ч байдаг юм уу, эсвэл багасгах асуудал нь магадгүй Спортын сайдын бүрэн эрхийн асуудал байхгүй юу.

Заавал яг e-sport дээр Үндэсний шигшээ баг байгуулна гэсэн яг хууль байхгүй. Тухайн Засгийн газрын гишүүн болоод Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусаж байгаа.

Ер нь бид спортын ямар чиглэлийг түлхүү хөгжүүлэх бодлого барьж зөөлөн хүчний бодлого гэдэг юм уу, үүнийг харж байгаагаараа л шалтгаалах юм билээ. Одоогийн байдлаар e-sport хүнсний шигшээ баг бүрдүүлсэн ийм зүйлтэй явж байгаа.

Хоёрдугаарт, Засгийн газраас өгс өгсөн санал дээр би Хүн амын орлогын албан татварын тухай хуулийг санаачлаад явж байсан. Үүнийгээ татаж авсан юм.

Тийм учраас энэ дээр Засгийн газрын саналуудыг аваад явсан.

Ер нь гааль, татварын асуудал маш хүндрэлтэй процесстой байгаа. Тэгээд Үндэсний олимпийн хороо болоод спорт холбоодоос заавал бичиг авч байж гаалийн татвараас хөнгөлөх чөлөөлөх гэсэн асуудал байдаг.

Тэгэхээр Үндэсний шигшээ баг бүрдүүлж байгаа энэ холбоод өөрсдөө харьцаад явах бололцоо нь цаашдаа ер нь анхаарах ёстой юм билээ. Тэгэхгүй маш их хэмжээний Монгол Улсад хүүхэд, залуучуудад зориулж спортын тоног төхөөрөмжийг хандив, буцалтгүй тусламжаар өгдөг. Энэ нөхцөл байдлаасаа болоод авч чаддаггүй орхидог зүйлүүд байж байгаа. Энэ чинь цэвэр хүүхдүүдийн зориулж байгаа л зүйл шүү дээ.

Тэгэхээр үүнийг татварын орлого бүрдүүлэлт гэхээсээ харах шаардлагагүй юм болов уу л гэж харж байгаа. Тэгээд энэ асуудлыг өргөжүүлж байгаа зүйл биш. Зүгээр аж ахуйн нэгж байгаад л боломж өгч байгаа шүү.

Тэр тусгай сангаар дамжуулна гэдэг бол хэзээ ч ийм төрлийн спортод харьцахгүй дээ. Энэ өөрөө эргээд мэргэжлийн лигүүдэд хамрагдаад ирэхээр нэр хүндийн асуудал, янз бүрийн байдлаар хэл аманд орохгүй ч гэдэг юм уу ийм шаардлагуудыг тавьдаг. Мэргэжлийн тамирчид чинь ийм зүйлтэй бараг орооцолдохыг хүсэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд Засгийн газрын тусгай санд өгнө. Нийтлэг байдлаар энэ дээрээс зөвхөн тэр e-sport, шатрыг дэмжээрэй ч гэдэг юм уу ингээд явахад их түвэгтэй.

Тэгэхээр зүгээр аж ахуйн нэгж, байгууллагуудад энэ 22.9 дэх заалтын дагуу хамтарч ажиллах боломжийг нь нээгээд өгөх нь хамгийн зөв сонголт юм. Энэ дээрээ тэр тамирчдыг дэмждэг юм уу, эргээд бараа, ажил үйлчилгээгээ тэр олон

сая үзэлттэй тэр спортоор дамжуулж л дэлхий нийтэд бараа, үйлчилгээгээ сурталчлаач л гэж байгаа юм.

Яг би бас тухайлан хоёр, гурван тэмцээнийг нь харсан. Тэр шөнийн. Хэдэн саяараа үзэж байдаг юм билээ. Тэгээд яг энэ маркетингийн зориулалтаар бас ингээд манай аж ахуйн нэгж, байгууллагууд 22.9-ийн заалтын дагуу хамтраад ажиллах юм бол бас л бараа, үйлчилгээг сурталчлан таниулахад хэрэгтэй юм болов уу л гэж энэ хуулийн төслийн агуугыг харж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Н.Наранбаатар: Хариулт хангалттай юу? Тооцоо, судалгаа байна уу? Өгсөн хүсэлт байна уу гэж байна. Индрийн микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ.

2025 онд ойролцоогоор хөрөнгө оруулалт дээр 20 орчим тэрбум төгрөг, хандив, тусламж дээр 7.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр урьдчилсан байдлаар бид нарын тооцоо тэгж гарч байгаа. Татварын ерөнхий газраас эцсийн байдлаар яг 1 хувийг эдлүүлнэ, эдлүүлэхгүй гэсэн нарийн тоо ирээгүй байгаа.

Н.Наранбаатар: Р.Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Би Үндэсний шигшээ баг байгаа юм уу л гээд асуугаад байгаа нь нэмэх гэж байгаа зүйл дээр чинь л 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн Үндэсний шигшээ баг, түүний харьяалагддаг спорт холбоо л гээд байгаа юм л даа. Тэгээд би Үндэсний шигшээ баг байгаа юм уу гээд асуугаад байгаа юм.

Тэгээд таны яриа чинь жоохон ойлгогдохгүй хоёр тийшээ явчхаад байна. Үндэсний шигшээ багтаа зориулж үүнийг авчрах гээд байна уу, эсвэл зүгээр e-sport-ийг хөгжүүлье. Залуучуудад зориулаад орж ирж байгаа тоног төхөөрөмжийг бүгдийг нь чөлөөлье гэсэн ийм агуулга яваад байна уу гэдэг л асуулт асуугаад байгаа юм. Одоо хаа сайгүй л РС-нүүд байна шүү дээ.

Тэгэхээр эдний оруулж ирж байгаа компьютер, тоног төхөөрөмжийг бүгдийг нь чөлөөлөх гээд байна уу? Эсвэл зөвхөн Үндэсний шигшээ багтаа зориулсан хэдэн хүн байдаг юм. Тэр чинь тэгээд 5-уулаа суугаад тоглодог байх. 10 ширхэг компьютер ч гэдэг юм уу. Үүнийгээ чөлөөлөх гээд байгаа юм уу? Үүнийгээ нэг тодорхой болгоод өгөөч ээ л гэж асуугаад байгаа юм.

Н.Наранбаатар: П.Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Үндэсний шигшээ багийн тухай асуудлыг л ярьж байгаа.

Түрүүн залуучууд тоог нь хэллээ. Энэ мэдээж дээш доош өгсөж байдаг тоо. Энэ удаа өнөөдрийн нөхцөл байдлаар 26 үндэсний шигшээ баг л байгаа юм байна.

Тэгэхээр энэ асуудал дээрээс илүү л тодорхой болгож өгье. Үндэсний шигшээ баг, үндэсний шигшээ багийн харьяалагдаж байгаа спорт холбоо гэдэг чинь л өөрөө энэ спортыг авч явна гэсэн үг шүү дээ. Түүнээс биш энэ спортын нэр бариад янз бүрийн байдлаар татвараас зайлсхийх гэдэг юм уу, ийм зүйлийг гаргахгүй. Зөвхөн мэргэжлийн холбоогоо дэмжээд, энэ холбоогоороо яг спортын тэр үйл ажиллагааг зүйлийг нь дэмжээд өгье л гэж байгаа юм.

Ер нь e-sport-ийг дэмжээд баг болгоныг дэмжинэ гэх юм бол энэ боломжгүй шүү дээ. Зүгээр энэ улс орныхоо нэрийг гаргах, яах аргагүй спортын сайдын шийдвэрээр үндэсний шигшээ баг бүрдүүлсэн тэр тамирчид болоод дасгалжуулагч нар тэгээд тэр холбоог нь л дэмжье гэж байгаа юм. Тэр холбоогоороо л дамжуулж энэ спортын үйл ажиллагаа... /минут дуусав/

Н.Наранбаатар: Би хоёр асуулт байгаа юм. Татварынхнаас асууя.

Тэр гаднын иргэний хандив, буцалтгүй тусламжаар тоног төхөөрөмж орж ирэхийг яаж мэдэх вэ? Яаж ялгаж салгадаг юм бэ гэж. Цаашдаа бүх тоног төхөөрөмж л энэ хүн хандивласан юм гээд чөлөөлөлтөд оруулна гээд гаалийн татвараас чинь бүгд зугтаах вий гэсэн болгоомжлол байгаа. Үүнийг ялгаж салгах тийм боломж байдаг юм уу, үгүй юм уу гэж нэгдүгээр асуулт.

Хоёрт нь, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг Татварын ерөнхий хуульд заачхаад байгаа юм л даа. Төсвийн хуультай хамт өргөн мэдүүлнэ гээд. Тэгээд Засгийн газар чинь сая татварынхаа хуулийг татаад авлаа шүү дээ. Намар төсөвтэй хамт өргөн мэдүүлнэ, дагалдуулна гээд.

Тэгэхээр энэ дээр П.Сайнзориг гишүүнээс. Төсөвтэй хамт, татварын багц хуулиудтай хамт нийлүүлээд Б.Пүрэвдорж гишүүний онцгой, НӨАТ, бүгдээрээ хамтруулаад, Ж.Баярмаа гишүүний хувь хүний орлогын албан татвар гээд ингээд хамт явах бололцоо байхгүй юм уу гэж. Ийм хоёр асуулт байна.

Эхлээд татварынхан хариулах уу? Тэр гаднын иргэний хандив, тусламж гэдгийг нь яаж ялгаж салгах юм? Гаалиар орж ирэхэд нь. Хэн хариулах вэ? Сангийн яам хариулъя. Индрийн микрофон өгье.

Ч.Чимидсүрэн: Ер нь тоног төхөөрөмжтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлтүүд нь Засгийн газрын тогтоол гараад хэрэгжээд явдаг.

Тэгэхээр тэр дээр шаардлагуудыг нь тавихдаа илүү тодотгох шаардлага гарна. Тэгээд энэ ямар эх үүсвэртэй байгааг нь.

Тэгэхээр 22.9-тэй холбоотойгоор цаашид хэрэгжих юм бол ийм маягаар явах тийм боломж л бүрдэх байх. Тэгэхгүй бол нэлээн тийм түвэгтэй байдал руу ороод энэ НӨАТ, гаалийн асуудал үүсэх болоод байгаа юм л даа.

Ер нь салбарын яам нь хүсэлтээ гаргаад, Биеийн тамир, спортын хороо салбарынхаа яаманд хандаад тэгээд салбарын яамнаасаа Сангийн яамны саналыг авч Засгийн газарт орж тогтоол нь хэрэгжээд явдаг ийм процедуртай байгаа. Хөнгөлөлтийн жагсаалтыг нь баталдаг юм.

Н.Наранбаатар: П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энэ ч утгаараа уг нь хүрээ хязгаарыг нь хумьж өгсөн юм шүү. Үндэсний шигшээ багт зориулж буюу яг албан ёсны Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан Үндэсний шигшээ багт зориулж өгч байгаа. Энэ өөрөө мэдүүлэг болон холбогдох бичиг баримтаар нотлогдох ёстой шүү дээ. Яг зориулалт болон хэнд өгч байгаа зүйл нь байх ёстой.

Тэгэхээр Монгол Улс өөрөө Биеийн тамир, спортын хуулиараа Үндэсний шигшээ баг байгуулж байгаа бол энэ зүйл дээрээ л хүрээ хязгаарыг нь хумьж өгч байгаа гэдэг зүйлийг хэлье.

Хоёрдугаарт, Засгийн газар гааль татварын, ер нь татварын багц хуулиа оруулаад ирвэл хамтатгаад явахад татгалзах зүйл байхгүй байгаа. Одоогоор тийм хуулийн төсөл байхгүй байна л даа.

Тэгэхээр би хууль санаачлах хүрээ хязгаарын хүрээнд л өөрийн бүрэн эрхийн хүрээнд Б.Бат-Эрдэнэ гишүүнтэй санаачилсан байгаа.

Тийм ч учраас татварын шинэ цаглавраас буюу төсвийн шинэ цаглавраас энэ асуудлыг үйлчлүүлж эхлэх нь зөв юм гээд 2027 оны 01 дүгээр сарын 01 гээд тавьсан байгаа. Энэ дээр ороод ирэхэд хамтатгаад явах ч гэдэг юм уу, ийм асуудал дээр нэг их татгазах... /минут дуусав/

Н.Наранбаатар: Гишүүд танилцуулгатай холбоотой асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Д.Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Хуулийн төсөлтэй холбоотой ер нь бид татвартай холбоотой хуулийн асуудлуудыг Засгийн газартайгаа нэлээн ярьж хэлэлцэж Засгийн газраас боловсруулж байгаа бодлогынхоо хүрээнд хамтад нь нэгтгэж явж байхгүй бол татварын асуудлыг сугалж яриад байх нь учир дутагдалтай юм байгаа юм.

Хэд хэдэн хууль дээр бид жишээлбэл яг гишүүд бүгд татварын асуудлын заал зүүлт болгоноор санаачлаад ч гэдэг юм уу, бүрэн эрхийнхээ хүрээнд яриад

байвал, өөр Эрүүгийн хуулийг ярьдаг байх аа. Тийм ээ. Энэ гол гол зарчмын шинжтэй хуулиудаа энд тэндээс нь оочин цоочин авч яваад байвал яг энэ үндсэн суурь зарчим нь алдагдах вий гэдэг болгоомжлол надад байна.

Бид дөнгөж сая Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэлэлцүүлгийг хийгээд гарч ирж байна. Үндсэндээ 38 удаа өөрчлөлт ороод, 90 хувь нь өөрчлөгдсөн явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тийм хэмжээнд суурь хуулиудаа өөрчлөхгүйн тулд яг энэ асуудлыг барьж байгаа төрийн захиргааны төв байгууллагын нэгэнт энэ хуулийн татварын багц хууль яригдаж байгаа цаг үед нэгтгээд, хамтатгаад орох нь зүйтэй байх гэж би бодож байгаа. Тэгэхдээ энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжээд хамтад нь оруулах юм уу, эсвэл наана нь хууль санаачлагчийн зүгээс өөрөө санаачлаад үүнийгээ нэгтгэе гэдэг байр суурьтай байх юм уу?

Миний хувьд хамтад нь нэгтгээд хэлэлцэх нь зүйтэй. Цаашдаа бид татварын бодлогыг багцаар нь, зөвхөн нэг татварын асуудлыг биш, бүх төрлийн татварын асуудлыг багцаар нь бодож бодлогын хэмжээнд авч явдаг байхгүй бол зөвхөн нэг салбарт зориулсан татварын өөрчлөлтүүд нь нь эргээд бусад салбартаа сөргөөр нөлөөлдөг энэ нөхцөл байдал руу орох вий.

Тэгэхээр эдийн засгийн агуулгаар нь бүхэлд нь харж явах нь зүйтэй гэсэн ийм саналыг хэлэх гэж байна.

Н.Наранбаатар: Д.Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Хуулийн техникийн хувьд болохоор яг нэг агуулгатай орлогын албан татвараас хөнгөлөх, НӨАТ-аас ч хөнгөлөх, гаалиас хөнгөлөх гэсэн яг ийм гурван татварын хуулийг нэгийг нь өргөн бариад нөгөө хоёрыг нь дагалдуулсан техникийн хувьд яадаг юм бол доо гэдэг ийм асуудал байна.

Тэгэхээр үүнийг анзаарна биз. П.Сайнзориг гишүүн хуульч хүн өөрөө анзаарна биз.

Миний хувьд болохоор ийм санал байгаа юм. Орлогын албан татвартай холбоотой хөнгөлөлт 22.9 бол энэ төсөв дээр ачаалал байхгүй, аж ахуйн нэгжүүдээс жишээлбэл санхүүжилт татах бололцоо боломжийг нээнэ гэдэг утгаараа. Үүнийг нь дэмжиж болж байгаа юм.

Нөгөө хоёр заалтыг нь болохоор П.Сайнзориг гишүүн татаад авбал уг нь бүр илүү амар юм биш үү? Яагаад гэвэл НӨАТ-тай холбоотой асуудал 38.1.27 гэдэг угаасаа энэ дээр хөнгөлөлт, чөлөөлөлт, гаальтай холбоотой асуудал нь хөнгөлөлт, чөлөөлөлтийн бололцоонууд нь байгаа учраас тэрийг тэр хуулиараа зохицуулах бололцоотой.

НӨАТ дээр болохоор ер нь хуулиар 29 л хөнгөлөлт, чөлөөлөлт байгаа юм байна. Тэр нь илүү голчлон салбартай холбоотой, нэлээн том бодлоготой холбоотой асуудлууд байдаг. Гэтэл яах вэ одоогийн зургаараа харахаар шатрын холбооны жишээлбэл үүнтэй холбоотой НӨАТ гэж юу байх вэ. Испортын хэдэн компьютерын НӨАТ. Нэг их том нөлөөлөл багатай учраас заавал энд НӨАТ-ын хууль дээр оруулах хэрэггүйгээр үүнийг хасвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм.

Тэгэхээр хэрвээ хуулийн төсөл хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл миний хувьд энэ орлогын албан татвартай холбоотой 22.9-тэй холбоотой заалтыг нь дэмжээд хоёр энэ дагалдуулсан гэж байгаа хоёр хуулийг нь дэмжихгүй байх ийм бодолтой байна.

Тэгэхээр П.Сайнзориг гишүүнийг энэ дагалдсан хуулиудаа хэрвээ татаж авдаг үүнийг ингээд нэг заалтаараа хэлэлцээд яввал яасан юм бэ гэсэн ийм бодол байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ өдрийн амгаланг эрье.

Яах вэ би энэ татварын орж ирж байгаа хуулиудыг агуулгынх нь хувьд уг нь дэмжээд байгаа юм. Тэгэхдээ бид жоохон бодох ёстой зүйлүүд байна. Мэдээж хэрэг энэ хуулийн тал дээр ач холбогдол талаасаа харах юм бол e-sport гэдэг Монголыг мэдэхгүй дэлхий нийтийн залуу үед Монголыг таниулж өгч байгаа байхгүй юу. Монголыг чинь ерөөсөө мэддэггүй шүү дээ. Тэр Африкийн оронд бүр ерөөсөө паг юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр тэр хэдэн саяараа үзэж байгаа хүмүүст Монгол гэж нэг Чингисээс өөр, ер нь тэгэхдээ байлдах чадвартай ард түмэн юм байна. Тулааны урлагт үнэхээр суралцсан мэргэжсэн хүмүүс байдаг юм байна гэдгийг эд нар чинь энэ залуу үед чинь харуулж өгөөд байгаа учраас энэ бол маш ач холбогдолтой ийм спорт гэдэг юм уу, ийм төрөл юм байна гэдгийг би ойлгоод байгаа юм. Үүнийг дэмжих ёстой байх.

Тэгэхдээ харин нэг сайн тал нь чи хуульч хүний хувьд 2027 оны 7 сарын 01-нээс гээд байгаа чинь зөв байхгүй юу.

Мөн тэр нефтийн тухай хуулиуд дээр би жоохон эргэлзээтэй нэг зүйл байгаа юм. Зөв. Яагаад гэвэл байна шүү дээ. Татварыг заавал төсөв дагуулахгүйгээр шийдэх ийм онцгой нөхцөл байдлууд одоо энэ дайн байлдаан, дэлхий нийтийн эдийн засгийн хямралтай холбогдоод үүснэ.

Тийм учраас нефтийн чиглэлээр авах гэж байгаа арга хэмжээ зайлшгүй байгаа юм. Тэгэхдээ бид нарт бас нэг хуулийн хязгаар гарч ирчхээд байна уу л

гэж би хараад байна л даа. Төсвийн хуулиар чинь бид төсвийн жил татварын орлогыг бууруулах хууль баталж болохгүй хуультай шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийг баталвал бид хууль зөрчсөн хэрэгт орно шүү дээ. Зайлшгүй нөхцөл байдал байна уу, байна. Бензин шатахууны үнэ өсөх гээд байна.

Гуравт, татварын асуудал Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал.

Тэгэхээр онцгой бүрэн эрхээ ингээд л нэг тийм Засгийн газартаа шилжүүлээд байдаг энэ байдлаас ер нь бид татгалзах ёстой. Оруулж ирээд л ингээд л ном журмаараа шийдүүлээд л явдаг юм байгаа биз. Тэгээд л бүрэн эрхээ Засгийн газарт шилжүүлээд байдаг энэ юмыг ерөөсөө зогсоох хэрэгтэй.

Ийм гурван асуудлыг анхаараач. Ялангуяа тэр төсвийн жил, татварын орлого буулгах хууль баталж болохгүй шүү. Дараа жилээс нь эхэлж хэрэгжүүлнэ шүү гэдэг заалт чинь хэвээрээ байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийг бид тэр нефть бүтээгдэхүүний хувьд зайлшгүй байна уу, зайлшгүй байна. Үнэ бүр талийх гээд байна шүү дээ. Гэтэл хуулийн ийм хязгаар байна уу, байна. Үүнийгээ зохицуулах тал дээрээ хандахгүй бол наадах чинь ингээд л. Ямар ч тохиолдолд бид тулж тэсэхгүй шүү дээ. Хууль тогтоох байгууллага. Тэгээд ийм юмнуудаа та хэд анхаараарай.

Харин тэр e-sport-ийг 2027-ны 01 сарын 01-нээс гэсэн юм байна. Тийм ээ? Тэр зөв. Хуульч хүний хувьд зөв шийдсэн байна.

Нөгөө асуудлууд дээр яах вэ хэдүүлээ. Ер нь энэ бензиний үнэ чинь талийх гээд байна шүү дээ. Бензин, түлш шатахууны үнэ чинь.

Зүгээр яах вэ, өнөөдөр нэг нааштай зүйл гарч байгаа нь гал зогсоох тухай яригдаад эхэллээ. Энэ сайн мэдээ. Энэ хуулиа яах вэ гэдэг дээр ярьж хэлэлцээд Та бүхэн санал хураалтаа хийгээрэй.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Би хоёр зүйл хэлье.

Би энэ e-sport гэдэг юмыг төрийн бодлогын хэмжээнд дэмжихийг би өөрөө дэмждэггүй юм. Энэ их буруу зүйл.

Дэлхийд Монголын нэр гаргаад явж байгаа нь сайн зүйл. Тэгэхдээ хэдүүлээ бизнесийн чиглэлийн юм спорт энэ тэр гээд жаахан ялгах л ёстой байх. Яах вэ, их олон оронд дэмжээд явдаг гээд байгаа. Тэр баян тансаг оронд юугаа дэмжих нь тэдний асуудал.

Би бол энэ хүүхдүүдийнхээ л, Монголын энэ залуу үеийг л нэг зөв юманд л уриалах ёстой. Тэр бол энэ нэг хөнгөлөн чөлөөлнө, элдэв юм ярьдаг юм бол хэрэгтэй юмаа л хөнгөл, чөлөөл. Хүүхдүүд тэндээ тоглоомоо тоглоод дэлхий дээр Монголынхоо нэрийг гаргаад явахыг хэн ч хаахгүй. Нээлттэй. Бизнесийнхээ шугамаар яваг. Сая доллароо олог. Наана цаана хамаагүй.

Та нарт тийм асуудал байдаггүй юм уу. Миний ойр орчмын хүмүүст энэ бөөн проблем байдаг байхгүй юу. Шөнө орой тоглодог, ингэдэг тэгдэг, наана цаана донтдог гээд л их олон юмтай шүү дээ.

Тэгэхээр би ер нь ерөнхийдөө та нар маань хуулийн төсөл оруулаад ярихдаа нэг ийм дүн шинжилгээ л хийх ёстой шүү дээ. Анализ. Тэр анализаа хийгээд төрийн түвшинд дэмжих ёстой гэдэг чинь нэлээн сайн нухацтай л хийх ёстой доо. Би ийм байр суурьтай хүн шүү.

Хоёрдугаарт, тэгээд үндэсний спортын түвшинд аваачаад олимп гэнэ үү, баахан юм болгоод явж гэж бодъё. Тэгвэл тэр татвар, хөнгөлөлт, чөлөөлөлтөө болиоч дээ. Хорин хэдэн хүний юмыг ч хөнгөлнө, чөлөөлнө. Наадах чинь өөрөө тэгээд л очоод л сая доллар аваад л тэгээд тэндээсээ хөгжөөд л явна биз дээ.

Үндэсний бөх нэг өөр хэрэг юм байна. Чөлөөт бөх дээр сонгодгууд бол өөр юм байна. Та нар нэг бодоорой. Залуучууд. Энэ бизнесийн чиглэлийн юм. Тэгээд хөл гараа хөдөлгөдөг барьдаг жинхэнэ спортын маягийн юм гэж би нэг ялгамаар л санагдаад байдаг юм. Би жоохон хоцрогдсон ч байж мэднэ.

Ер нь тэгэхдээ үүнийгээ далимдуулж тэр нэг баахан хөнгөлөлт, чөлөөлөлт өгдөг буруу. Би Сангийн сайд байсан хүн. Одоо ер нь та нар ухасхийнгүүт л юм чөлөөлнө, хөнгөлнө гээд л. Тэгээд яг Ц.Даваасүрэн гишүүдийн санал нэг байна.

Одоо тэр бензин шатахуун, жаахан тулсан, олон хүнд хүртээмжтэй тийм юман дээрээ төрийн бодлого гэдэг юм нь уян хатан хурдан явмаар байна. Би үүнийг ер нь дэмжихгүй байгаа. Тэгэхдээ би өөрийнхөө саналыг л хэлж байгаа юм шүү.

Н.Наранбаатар: Х.Булгантуяа гишүүн үг хэлнэ.

Х.Булгантуяа: Би хэрвээ ийм хөнгөлөлт, чөлөөлөлт байвал ер нь Монголын бүхий л шигшээ багийн спортод бараг өгөх ёстой гэж бодож байна. Түүнийг онцолж ганцхан e-sport ч гэдэг юм уу, ингэнэ гэдэг бол.

Ер нь спортыг хооронд нь ялгаварлана гэдэг бол ерөөсөө үр дүн муутай шүү дээ.

Дэлхийд өнөөдөр Монголын нэрийг гаргаад явж байгаа нь ганцхан спорт ч биш. Сагсан бөмбөгөөс авхуулаад л олон төрөл дээр Монголчууд амжилт гаргаж

байна. Цаашдаа ч гэсэн Монголын спортсменүүд амжилт гаргах байх гэж бодож байна.

Тэгээд саяын 1 хувийн хөнгөлөлт, чөлөөлөлт спортод их нэмэр болсон. Тэр аягүй сайшаалтай. Одоо бараг томоохон аж ахуйн нэгжүүд татварт мөнгөө төлж байсанд орвол өөрийнхөө нэрийг гаргаад спортын багтай болгоё, жерсийг нь өмсгөөд ингээд сагсан багийг спонсордъё ч гэдэг юм уу, сагсны багийг спонсордъё ч гэдэг юм уу ийм хандлага явж байгаа нь их сайшаалтай.

Түрүүн Д.Энхтүвшин гишүүн хэлж байсан уу? Тийм ээ. Шинжлэх ухааных нь талынх нь харин энэ журам, бичиг цааснууд нь гарахгүй байгаа юм байна лээ.

Тэгэхээр би магадгүй Н.Наранбаатар дарга Төсвийн байнгын хорооноос би үүнийг маш чухал гэж бодоод байгаа юм. Шинжлэх ухааны талынхыг. Манай ШУТСан дээр өгч байгаа мөнгө, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сан дээр өгч байгаа мөнгө бага. Гэхдээ тэр нь Монгол Улс шинжлэх ухааныг дэмждэггүй гэсэн үг ерөөсөө биш. Аж ахуйн нэгжүүд өөрөө зөндөө их санхүүжилтүүдийг хийдэг. Түүнийгээ ерөөсөө бид тооцож чаддаггүй.

Тэгэхээр үүнийгээ давхар тооцох хэрэгтэй. Тэгээд би үүнийг эхний шатанд ямар ч байсан e-sport гэж оруулж ирж байгаа юм байна. Тэгээд дэмжээд явъя. Тэгэхдээ би эсрэгээрээ жоохон өргөжүүлэх ёстой гэж бодож байна. Үүнээс нэг их.

Би яг бодит үнэнийг хэлэхэд Монголын шигшээ багийнхан нэг их тоног төхөөрөмж оруулж ирээд л, түүнээс хэдэн тэрбумын татварын орлого алдаад. Тийм юм бага гэж бодож байна. Нэгдүгээрт. Төсөв дээр үзүүлэх нөлөөлөл энэ харьцангуй бага байх.

Харин Монгол Улсын нэр хүндэд үзүүлэх нөлөөлөл их байгаа байх. Тэгээд би ийм жишээнүүд мэддэг юм. Миний мэдэх нэг тамирчин гэхэд олон улсын тэмцээнд оролцоод Азийн том тэмцээнээс аймаар өндөр үнэтэй дугуй шагналд нь авсан чинь шагналдаа авсан дугуйгаа Монголд оруулж ирэх гээд татвар төлж байгаа юм. Тэгээд энэ чинь аймаар утгагүй шүү дээ. Тэгээд өөрөө бараг шигшээ багийн тамирчны хэмжээний хүн байхгүй юу.

Тэгэхээр бид нарын монголчуудын Монголын төр, засгаас үнэнийг хэлэхэд тэр нэг Биеийн тамир, спортыг дэмжих сан дээр нэг хэдэн төгрөг. Тэгээд л төсвийн хэмнэлт явуулна гэхээр хамгийн түрүүнд биеийн тамир, спортоосоо мөнгийг нь хасаад. Тэгээд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт энэ тэр болохоороо яг үнэнийг хэлэхэд манай биеийн тамир, спортын салбар байнга хойно үлддэг.

Тэгээд би үүнийг нэг их тийм том татварын хуулийг харж байж хийх ёстой биш. Мэдээж төсөвт үзүүлэх нөлөөллийг нь үзэх хэрэгтэй. Тэгээд шаардлагатай бол 2027 оноос хэрэгжиж эхлэх нь зүйтэй. Үүний төсөвт үзүүлэх нөлөөлөл тийм их биш нь угаасаа тодорхой. Ингээд дэмжээд явах нь зүйтэй байх. Бараг эсрэгээрээ энэ бол манай Монголын шигшээ багуудын хувьд өөрсдийнхөө

хэрэгцээнд авч байгаа техник, тоног төхөөрөмжөөс авхуулаад олон зүйлүүд дээр хөнгөлөлт, чөлөөлөлтүүд явах ёстой гэж бодож байна.

Н.Наранбаатар: П.Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. Гишүүддээ.

Тэгээд үзэл баримтлалын хүрээнд нь дэмжээд хэлэлцэх юм бол би бас нөгөө хууль санаачлагчтайгаа тэр дагаж байгаа хоёр хуулийн төслийг яах вэ ийх вэ гэдгийг Д.Энхтүвшин гишүүний саналыг ярилцаад шийдэх боломжтой. Хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа.

Хоёрдугаарт, Н.Алтанхуяг даргын хэлж байгаа саналыг ойлгож байна. Гол нь энэ залуучууд маань бусад аж ахуйн нэгж, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага юм уу, эсвэл санхүүжилт олдохгүй болохоороо **1xBet**¹-ийн буюу Тийм. **1xBet** мэтийн ийм манайдаа хууль бус гэж хэлж болох компаниудын логог сурталчлах байдалтай энд ингээд яваад байгаа юм.

Тэгэхээр бид хэд үүнийг дотооддоо сая хориглосон шүү дээ.

Тэгэхээр яагаад залуучуудын “jersey”² гэдэг юм уу. Энэ хэдийгээр e-sport боловч өмсгөл дээр нь говийн эмблем байж болохгүй байгаа юм. Өөр ямар компаниуд билээ. MCS-ийн эмблем ч байдаг юм уу, АПУ-гийн эмблем байж болохгүй байгаа юм бэ л гэдэг зүйл байгаа. Тэрийг үзэхээр маш их хэмжээний мерчендайз ард нь явдаг юм байна. Ерөнхийдөө хэдэн сая үзэгчтэй.

Тэгэхээр энэ аж ахуйн нэгж байгууллагууд яг нөгөө нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн орлогын тодорхой хувь буюу 1 хувийг зарцуулж байгаа энэ хүрээндээ л энэ e-sport, шатар хоёр л орж ирж байгаа. Бусад нь аль хэзээ ингээд хумиад өгсөн байхгүй юу. Зөвхөн олимпын төрлийн спорт, паралимпын төрлийн спорт, эсвэл үндэсний олимпын төрлийн олимпын хорооны гишүүн холбоодод л энэ эрх нь байгаад байсныг нэмээд зүгээр энэ 2 үндэсний шигшээ баг бүрдүүлсэн 2 шигшээ баг орж ирж байгаа. Бусад 24 нь аль хэзээ хамрагдаад явж байна гэж логик харагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэд цаашдаа би энэ дээр ингээд яах вэ e-sport талдаа тулгуурлаад ярьсан. Ер нь зүгээр аль спортыг төрлийг хөгжүүлэх гэдэг тухайн төрийн бодлогын асуудал юм билээ.

Тэгэхээр үүнийг яах вэ хэлэлцэхийг нь шийдээд ингээд зарим саналуудыг шийдээд явахад бэлэн байна. Тэгээд ер нь зүгээр яах вэ дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудад хамтарч ажиллах боломжийг нь өгөх гээд байгаа юм шүү.

¹ Онлайн мөрий (betting) болон мөрийтэй тоглоомын (gambling) платформ.

² Хувцаслалтын хэв маяг.

Түүнээс биш яг үүний спорт болон шатрын спортод төрөөс мөнгө өгөх гээд байгаа зүйл биш. Тэр нэг хувийн хөнгөлөлттэй энэ спортыг хамруулаад хоорондоо бизнесийн яриа хэлэлцээ дэмжлэг энэ тэрээ үзүүлээд яв л гэдэг энэ боломжийг нээж өгье л гэж байгаа юм. Тэгээд Та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье.

Н.Наранбаатар: Би үг хэлье.

Ер нь оруулж ирсэн хуулийн төслийг агуулгынх нь хувьд дэмжиж байгаа. Хувь гишүүний хувьд. Энэ төслөөрөө 2027 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх юм байна. Хэрэгжиж эхлэх хугацаа болоогүй байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргын захирамжаар Л.Соронзонболд гишүүнээр ахлуулаад татварын хуулийг боловсронгуй болгох ажлын хэсэг ажиллаж байгаа.

Дээрээс нь нэмээд хэд хэдэн гишүүд татварын хувь хэмжээг бууруулахаар өргөн барьсан.

Жишээ нь, Ж.Баярмаа нарыг 30 хэдэн гишүүний өргөн барьсан Хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгох.

Энэ хэрвээ батлагдвал –

▶ 5.2 их наяд төгрөг байхгүй болох юм билээ. Төсвийн орлогоос.

Дараа нь Б.Пүрэвдорж гишүүн чинь НӨАТ-ын 10 хувийг 5 хувь болгох хуулийн төсөл өргөн барьсан.

▶ Үүгээр 5 гаруй их наяд төгрөг байхгүй болох юм билээ.

Ингээд 10 гараад явна. Ингээд энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гээд маш олон гишүүн.

Засгийн газрын өргөн барьсан нь 2.7.

▶ 2.7-г Тогтвортой байдлын зөвлөл үзээд 3.7 их наяд төгрөг байхгүй болох юм байна гэж байгаа.

Ингээд л зүгээр ерөнхий бодоход ингээд 10 хэдэн их наяд төгрөг, 15 орчим их наяд төгрөгөөр төсвийн орлого чинь ирэх онд байхгүй болох гээд байгаа юм л даа.

Тийм. Нөгөө 50 хувиар төсвийн орлого маань ингээд алга болох гээд байгаа юм.

Тэгэхээр чинь татвар гэдэг чинь өөрөө уялдаа холбоотой байх ёстой шүү дээ. Тэгээд нөлөөлөл нь төсөвт нөлөөлдөг. Төсвийн хүрээнд нөлөөлдөг. Тэгээд цаашаа улс орны амьдрал гээд явдаг учраас оочин цоочин энд тэндээс нь гишүүд санаачлаад байх нь логикгүй юм.

Хэдийгээр гишүүд хууль санаачлах эрхтэй ч гэсэн. Тэгэхээр миний санал бол бүгдийг нь тэр Л.Соронзонболд гишүүний ажлын хэсэг дээр. Үүний хэлэлцэх эсэхийг нь дэмжээд бүгдийг нь тэнд нийлүүлж байгаад системтэй бүхэлд нь авч үзвэл яасан юм бэ гээд. Тэгээд төсөв өргөн барихдаа Татварын ерөнхий хуулийнхаа дагуу дагалдуулаад Их Хуралдаа өргөн бариад явах нь нэгдсэн тооцоолол хийхэд зөв юм болов уу л гэсэн ийм л саналтай байна.

Нефть үүний дараа ярина. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Энэ бол угаасаа нээгдсэн харилцаа байхгүй юу. 1 хувийг бид аль цагийг өгсөн. Харин одоо хамрах гээд байгаа хүрээн дээр нь тодорхой нэмж өгөх тухай л ярьж байгаа юм.

Тийм учраас энд ямарваа нэгэн асуудал байхгүй. Би үүнийг нь дэмж ёстой гэж ойлгож байна.

Харин П.Сайнзориг гишүүн тэр нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг харах ёстой. Гааль дээр яг тов тодорхой гарал үүслээрээ орж ирж байгаа юман дээр тэр учиргүй ч үнэтэй юм байхгүй. Угаасаа ойлгомжтой. Тэрийг нь зохицуулах юмаа Та хэд хэлэлцүүлгийн түвшиндээ. Тийм ээ. Дахиж нэг сайн судалж яриарай гэдгийг би зориуд хэлмээр байна.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт. Гишүүд орж ирээрэй. Санал хураалт явна. Санал хураалт. /алх цохив/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

Нийт 16 гишүүнээс 9 хүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 6 хүн дэмжсэн санал өгч 37.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан

татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураана. Саналын томьёолоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 31.3 хувиар дэмжигдсэнгүй.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуулийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Б.Мөнхсоёл гишүүн танилцуулна.

**Хоёр. “Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хоёр дахь асуудал. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны 4 сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийг оролцуулаарай. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга, Чулуунбаатарын Тамираа Гаалийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ж.Батжаргал гишүүнээр тасалъя. Ц.Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Тийм ээ. Надаад нөхцөл байдал тун амаргүй байна.

Тодорхой нааштай юм шиг нөхцөл байдлууд үүсэж байна гэж ярьж байгаа боловч тодорхойгүй байдал нь тодорхойгүйгээр үргэлжилж байгаа байхгүй юу. Цаашаагаа.

Тийм учраас дэлхийн зах зээл дээр бий болсон үнэ ханш нэг хэсэг тогтвортой байгаад байж мэдэхээр байна гэж. Нэг.

Хоёрдугаарт, нэгэнт л мөргөлдөөн явж байгаа учраас гол үйлдвэрлэл болсон объектууд дээрээ онилоод үйл ажиллагаа явуулсан. Нэлээн их дэлбэрэлтүүд явсан. Энэ газрын тосны бүтээгдэхүүний чинь нийлүүлэлтийг нь хийж байгаа тэр объектууд чинь хэвийн үйл ажиллагаа гэдэг юм уу, хүчин чадлынхаа түвшинд хэзээ хүрч нийлүүлэлт хэвийн нөхцөл рүүгээ шилжих юм гэдэг асуудал бас нэлээн тийм эргэлзээтэй асуудал байгаа юм.

Тийм учраас 100 хувь импортын хамааралтай улс орны хувьд ер нь энэ гадаад, дотоод нөхцөл байдлуудаа зөв үнэлж, үүссэн нөхцөл байдалдаа шуурхай хариу арга хэмжээ авах, ер нь энэ бүтээгдэхүүнээр дамжиж иргэд, аж ахуй, бизнесийн байгууллага дээр ирэх үнийн өсөлтийн дарамтыг тодорхой тохируулгаар бага ч болтугай өсөлтийг нь бууруулж байх бололцоо боломжийг нь Засгийн газартаа өгсөн нь дээр.

Тийм учраас би энэ тогтоолыг дэмжих нь зүйтэй байна гэж зориуд хэлмээр байна.

Хоёрдугаарт, би даргад нэг зүйл хэлмээр байна. Би Ерөнхийлөгчтэй цуг тодорхой аж ахуйн байгууллагууд дээр ажиллах хөтөлбөртэй юм байна. Тэр дагуу хөдлөх гээд байна.

Гурав дахь хэлэлцэгдэж байгаа асуудал дээр дэмжмээр байгаа. Яагаад би тэгж байгаа вэ гэхээр гадаадын зээл ашиглалтын асуудлыг би хоёрхон төсөл дээр ярьж байгаа.

- Газрын тос боловсруулах үйлдвэр.
- Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц.

Өөр нэмж төсөл оруулахыг нь энэ хуулиар нь хориглож хаасан.

- ▷ **Нэгдүгээрт**, одоо байгаа төсвийн тусгай шаардлагаа бариад явна гэх юм бол бид хэд газрын тос боловсруулах үйлдвэр дээр авсан зээлийнхээ үлдэгдлийг ашиглахад бараг арваад жил шаардлагатай болоод байгаа.

Гэтэл дуусаагүй үйлдвэрлэлд аваад ашигласан зээлдээ төлж байгаа хүүгээ тооцож үзэх юм бол энэ зээлийн чинь өртөг өндөржөөд болж өгөхгүй байна. Нэг.

- ▷ **Хоёрдугаарт**, авч ашиглаж чадаагүй байгаа зээлийнхээ үлдэгдэлд бид хураамж төлнө.

Тэгэхээр энэ нөхцөл байдал бүр хүндрэх нь. Тэгээд энэ гадаа байж байгаа нөхцөл байдал чинь ийм хүнд байгаа үед ядаж энэ үйлдвэрээ 2028 он гэхэд бүтэн ашиглалтад оруулж яваад, шаардлагатай шатахууныхаа 50 хувийг дотоодоосоо хангадаг юм руугаа орох нь бид зөв. Энэ бол үндэстний эрх ашиг.

1 минут нэмээд өгчхөөч.

Н.Наранбаатар: Ж.Батжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Үүнийг бид шийдмээр байна.

Би төсвийн тогтвортой байдал, төсвийн талаарх бодлого, эрх зүйн орчин бүрдүүлж ажиллаж байсан Их Хурлын гишүүд, энэ бүх хүмүүст хүндэтгэлтэй ханддаг. Үнэхээрийн бид төсөвтөө тусгай шаардлага тавьж, төсвийн хариуцлага сахилгаа сайжруулж байсан.

Гэхдээ энд яг ингээд түгжээд суугаад байх юм бол бид урагшаа алхахгүй нь. Энд ямар зохицуулалт хийх ёстой вэ?

Би бодоод байгаа юм. Өрийн тааз чинь 10 орчим пункт хувийн орон зай байна.

Тэгэхээр Өрийн удирдлагын тухай хуулийнхаа таазанд баригдаад өөрөө өөрийнхөө үйл ажиллагаагаар Монголын эдийн засаг, нийгмийн амьдралд нэлээн томоохон түлхэц өгөхөөр энэ том төслүүдийг урагш нь явуулахад бас бидэнд тусгай бодлого хэрэгтэй болоод байна.

Ийм эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөхгүйгээр бид урагшаа явах боломжгүй.

Н.Наранбаатар: Асуулт асуусан уу? Үг хэлсэн. П.Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа.

Би уг асуудлыг дэмжиж байна. Түрүүн Ц.Даваасүрэн дарга хэлээд л байна. Бид хэд тодорхой түвшинд аливаа асуудлын хууль батлах гэдэг юм уу, квотын асуудлыг ярихгүй бүх зүйлүүдийг хугацаа юм уу, эсвэл нэг ийм зүйлүүдээр хориглоно, хязгаарлана гээд өөрөө өөрсдийгөө түгжээд байгаа юм.

Үнэхээр парламентын дийлэнх олонх нь зарим асуудлыг үнэхээр хүлээн зөвшөөрч байвал уг нь шийдээд явах ёстой. Ингэж байж л парламент асуудлаа шийдэх ёстой байхгүй юу.

Түүнээс биш цаг хугацаагаар нэгэнт гар хүрсэн асуудал дээр дахиад 6 сар хүрч болохгүй ч гэдэг юм уу, эсвэл тодорхой тодорхой шаардлагуудыг тавиад хүрч болохгүй гээд байхаар парламент чинь гадаад, дотоод нөхцөл байдлыг харж байгаад ямар ч асуудлыг ямар ч цаг хугацаанд уг нь татаж авч хэлэлцээд улс орныхоо язгуур эрх ашгийн төлөө явах ёстой л гэж би харж байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ хаана хаанаа ойлголцлуудыг явъя.

Хоёрдугаарт, техникийн хувьд нэг зүйлийг хэлье л гэсэн саналыг авсан юм.

Татварын ерөнхий хууль батлагдсан. Татварын ерөнхий хуулиар –

- татварыг бий болгодог,
- татварыг чөлөөлдөг,
- татварыг хөнгөлдөг,
- татварыг хүчингүй болгодог.

Гэтэл энэ чинь өөрөө Улсын Их Хурлын тогтоолоор яваад байгаа шүү. 90-ээд оноос хойш. Тэгээд ойлгомжгүй. Яг энэ дээр тодорхой хэмжээний үр нөлөө болоод хуулийн хэрэгжилт ямар байдлаар нөлөөлж байгаа юм. Асуудлыг ярьдаггүй зүйл байгаа.

Тэгэхээр энэ удаадаа ингээд шийддэг юм байгаа биз.

Ер нь цаашдаа энэ асуудлыг тодорхой хэмжээнд аль хуульд оруулах ёстой байдаг юм. Хуульчлах ёстой юм. Энэ өөрөө хууль зүйн техник, шаардлагын асуудал шүү.

Энэ ингээд яваад байгаа нь их зохимжгүй нөхцөл байдалтай болоод байна шүү гэдэг зүйлийг л хэлье.

Тэгээд ер нь яах вэ, асуудлыг дэмжиж байна. Зарчмын хувьд дэмжиж байна. Өнөө маргаашдаа ийм жижиг хариу арга хэмжээнүүдийг авч байна. Жижиг биш гэж хэлж болохгүй юм аа. Ер нь хариу арга хэмжээнүүдийг авч байна.

Дунд хугацаандаа яах вэ гэдэг асуудал дээр бид хэд нарийн төлөвлөгөө гаргаад, Ж.Батжаргал даргын хэлж байгаа шиг тэр гадаад зээллэгийн асуудал, хуулийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх хууль энэ тэрээ яаралтай батлах, газрын тосны үйлдвэрээ яаралтай ашиглалтад оруулах энэ хэмжээ дамжаа чинь ер нь гадагшаа орж байгаа мөнгө чинь 2.2 тэрбум долларт хүрэх гээд байна гэж байна шүү дээ. Тийм ээ.

Ядаж үүнийхээ 50 хувийг ч гэсэн Монголдоо авч үлдэх асуудлыг цаг хугацааны хувьд наашлуулж авчирмаар байна. Тэр 10 жилийн дараа гэдэг зүйл байж болохгүй шүү дээ. Авсан зээлээ ашиглаж чадахгүй.

Тэгэхээр ийм зүйлүүдийг яах аргагүй Засгийн газар, гишүүд маань анхаарч шийдэж өгөөч ээ. Шийдэхэд идэвхтэй оролцоотой. Тэгээд асуудалд практикал хандаач ээ, прагматик хандаач ээ л гэж хүсэж байна.

Тэгээд хууль зүйн техникийг Засгийн газрын төлөөллүүд цаашдаа анхаараач ээ. Уг асуудал Улсын Их Хурлын тогтоолоор зохицуулагдаад явах нь Татварын ерөнхий хууль болон бусад юугаараа боломжгүй байгаа шүү. Энэ ингээд л яваад байгаа юм. Хэн ч ярихгүй байгаа юм.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Ц.Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Тийм. Би тогтоолтой холбоотой хөндсөн л дөө. Энэ тогтоол чинь өөрөө ингээд 2026 оны 01 сарын 01-нээр хүчингүй болоод байгаа юм.

Тэгэхээр яасан байна вэ гэвэл энэ тогтоолд хамаарч байгаа төсвийн орлого төсөвт туссан гэсэн үг байхгүй юу. 2026 оны төсөв дээр.

Тэгэхээр хуулиараа бид нарт тухайн жилийн төсвийн орлогыг бууруулах шийдвэр гаргаж болохгүй гэсэн байгаад байдаг. Тэгээд хуулийн хувьд бид ингээд хязгаарлагдмал. Тэгэхдээ амьдралд зайлшгүй энэ арга хэмжээг авах шаардлага байна уу байна.

Тэгээд би гишүүнээр ажиллах хугацаанд ер нь хууль зөрчсөн аливаа асуудалд санал өгч үзээгүй. Дэмжиж. Одоо болохоор ингээд нэг тийм эвгүй байдалд орж байна шүү дээ. Яг хууль зөрчигдөөд байдаг. Төсвийн орлогод тооцогдсон орлого байгаад байдаг. Тэгэхдээ амьдрал үнэхээр ийм арга хэмжээ авахгүй бол шатахууны үнэ тэнгэрт тул гээд байдаг. Гадаад нөхцөл байдал сайжрахгүй.

Сая Трамп нэг шөнийн дотор дэлбэлнэ гэхээр нөгөөдүүл нь хөрш орнуудынхаа бүх нефтийн байгууламжуудыг дэлбэлнэ гээд л энэ хоёр чинь гал түр зогсох хэлэлцээр орж байна шүү дээ. Тэгээд энэ нь цаашдаа хэр явах юм. Саудын Арабын хамгийн гол нефтийн баазын 70 хувийг хангадаг юуг нь харвачхаж байна. Тэгээд тэрийгээ сэргээх гэж ямар хугацаа шаардах юм бүү мэд.

Тэгэхээр энэ шийдэх шаардлага байна уу байна. Тэгэхдээ хууль зөрчигдөх гээд байгаа асуудлаа яах вэ гэдэг юмыг хэдүүлээ нэлээн сайн ярьж байж л хийхгүй бол энэ чинь 01 сарын 01-нээс хүчингүй болсон учраас төсвийн орлого зайлшгүй тооцогдох ёстой эд байгаа байхгүй юу.

Төсөв гэдэг чинь тухайн үйлчилж байгаа татварын хуулийн хүрээнд хийгддэг ийм хуультай байхгүй юу. Төсөв өөрөө.

Тэгэхээр энэ зайлшгүй тооцогдсон байгаа. Тийм. Тэгэхээр одоо яах вэ гэдэг асуудал. Хоёр бол тийм.

Ер нь татвар бол хуулиар зохицуулагдаж байх ёстой юмыг Их Хурал онцгой бүрэн эрхээ Засгийн газарт шийдүүлээд тогтоолоор зохицуулаад байдаг нэг ийм буруу практикийг түрүүн П.Сайнзориг гишүүн хэлж байна. Бусад гишүүд хэлж байна. Энэ бол уг нь буруу практик. Тэгэхдээ үүнийг цаашдаа Их Хурал засаад явах ийм шаардлага байна.

Тэгээд хэдүүлээ наад асуудал дээрээ нэлээн хуулийн зөвлөгөө авч байгаад хийхгүй бол ер нь хуулийн зөрчилтэй ийм алхам хийгдэх гэж байна гэдгийг би протоколд үлдэх гэж байгаа юм.

Н.Наранбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас нэг тайлбар сонсьё. Ц.Даваасүрэн гишүүний хэлсэн үгтэй холбогдуулаад.

Сангийн яам Ч.Чимидсүрэн дарга. Энэ дээр нэг тайлбар хэлээдхээч. Протоколд үлдээнэ. Индрийн микрофон.

Ч.Чимидсүрэн: Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн.

Тэгэхээр 1999 оны 27 дугаар тогтоолоор АИ92-ын гаалийн татварыг тэглээд өнөөдрийг хүрсэн. Өөрөөр хэлбэл 2026 оны 01 сарын 01-нд тэр тогтоолынх нь үйлчлэх хугацаа дуусаад байгаа байхгүй юу.

Гэхдээ 2026 оноос хойшхид нь бид гаалийн татвар аваад явж байгаа. Яагаад гэвэл тогтоолын хүчин төгөлдөр хугацаанд аваад явж байгаа. Өнөөдрийг хүртэл аваад явж байгаа гэсэн үг.

Ер нь Евразийн хэлцэлд энэ асуудал орсон бол гаалийн татвар нь тэглэгдэх юм байна гэсэн тооцоололтойгоор явагдаад үүнийг яг шууд залгаад явах тийм хугацаан дээрээ юу гарсан, гар_[завсар] гарсан ийм асуудал байгаа юм.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Үгүй. Энэ орлого тооцогдсон. Үйлчилж байгаа. Ингээд 01 сарын 01-нээс зогссон хуулийн чинь орлогын татварыг нь авсан байна.

Тэгэхээр ахиад ийм асуудал үүсэж байгаа байхгүй юу. Үүнийг чинь ингээд сунгахаар нөгөө авсан татвараа буцааж өгөх асуудал ахиад үүсэж байгаа учраас нөгөө төсвийн орлого бууруулж болохгүй гэсэн хуультай чинь бүр илт зөрчилдчихөөд байгаа байхгүй юу.

Тэгээд одоо үүнийг яаж шийдэх юм бэ гэдгийг л би хэлээд байгаа юм. Яагаад гэвэл 01 сарын 01-нээс энэ татварыг чинь авсан байгаа. Авах ёстой. Яагаад гэвэл энэ хууль чинь үйлчлэхгүй болсон юм чинь.

Гэтэл одоо үүнийг ингээд сунгахаар нөгөө авсан татварыг чинь буцааж өгөх чинь төсвийн орлогыг бууруулаад байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам тайлбар хэлье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газар.

1999 оны 27 дугаар тогтоолд тогтоол дээр нөгөө гаалийн албан татвар тогтоох тухай жагсаалтын 27 дугаар заалтыг нэмж оруулж байгаа. Ийм Их Хурлын тогтоол гарч байгаа. Тогтоол батлагдсан өдрөөс үйлчилж эхэлнэ. Хойшоо үйлчилж эхэлнэ.

Тогтоолын төсөл ерөөсөө хэрэгжиж эхлэх хугацаатай байгаа.

Н.Наранбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Индрийн микрофон. Хариулт.

Ч.Хишигдалай: АИ92 авто бензинээс сард 8-аас 10 тэрбум төгрөгийн гаалийн албан татвар бүрдүүлдэг. Дизель түлш дээр 23-аас. Үнээсээ хамаараад 30 орчим тэрбум төгрөгийн гаалийн татвар бүрдүүлдэг.

Гэхдээ 2026 оны төсвийн тухай хуульд Евразийн эдийн засгийн холбоонд элсэнэ, 8 дугаар сараас гэж тооцоод төсөвт орох орлогыг тооцсон тоо ойлгосон. 4 сар хүртэлх татвараа аваад явж байгаа.

Тогтоол хүчинтэй болсноос хойш татварыг нааш цааш нь тохируулах асуудлыг Засгийн газрын тогтоолоор шийдээд явна.

Н.Наранбаатар: Би энэ тогтоолын төслийг нь уншаад өгье. Ийм юм байна.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Гаалийн тариф гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь гээд 2 заалттай.

1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолыг 4 дэх заалтын “2026” гэсний дараа “2027” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг 2026 оны 4 сарын 01-ний өдрөөс эхлэн 2028 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.

Энэ 2 дугаар заалтаараа 4 сарын 01-нээс 2028 оны 12 сарын 31 гэсэн юм байна. Өмнөх нь болохоор сунгаж байгаа юм шиг.

Гишүүд үг хэлж, асуулт асууж дууссан. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаа хамаарахгүй. Тогтоолын хэрэгжих хугацаатай холбоотой нэг зарчмын зөрүүтэй санал байгаа. Саналыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Миний хувьд зарчмын зөрүүтэй нэг санал гаргаж байгаа. Энэ хугацаатай холбоотой юм. Түрүүн 4 сарын 01 гэж байсан. Одоо 4 сарын 01 өнгөрөөд явсан.

Тогтоолын төслийн 2 дахь заалтын “4 сарын 01-ний өдрөөс эхэлнэ” гэснийг “4 сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх. Ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар.

Зарчмын зөрүүтэй санал дээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Ж.Батжаргал гишүүн хүсэлт гаргасан учраас ирцээс хасъя.

Ц.Даваасүрэн гишүүн горимын санал.

Ц.Даваасүрэн: Амьдрал шаардаж байна уу, шаардаад байна. Тэгэхдээ гишүүд маань илт хууль зөрчсөн шийдвэрт оролцохгүй гээд байгаа чинь бас хүчээр шахах ямар ч аргагүй байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ амьдрал шаардаж байгаа асуудлыг яг одоо санал хураах гэхээр хэрвээ бүрдэхгүй байгаа бол санал хураахгүй хойшлуулаад бүлгийн даргаа байлгаж байгаад хураавал яасан юм. Тэгээд аваад гарвал.

Н.Наранбаатар: Хойшлуулъя гэсэн горимын санал гаргалаа. Санал хураалт явуулна. Гишүүн горимын санал гаргасан учраас горимын.

Зарчмын зөрүүтэй саналаар эхлээд санал хураана. Томьёоллыг дахиад. Сая зарим хүн нэмэгдээд ороод ирсэн учраас дахиад уншъя.

Тогтоолын төслийн 2 дахь заалтын “4 сарын 01-ний өдрөөс эхлэн” гэснийг “4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар.

Санал хураалтад бэлдье. Гишүүд бэлдсэн үү? Санал хураалт. /алх цохив/

15 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 86.7 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулна.

Ц.Даваасүрэн гишүүн микрофонд хэлье.

Ц.Даваасүрэн: Тэгвэл санал хураалт хийе гэж байгаа юм бол би саналаа татъя. Хойшлуулъя гэдгээ.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүн горимын саналаа татлаа.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? П.Сайнзориг гишүүн танилцуулна.

**Гурав.Гадаад зээллэгийн ашиглалт,
үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн
2026.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Гурав дахь асуудал. Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна.

Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ч.Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал нэгдүгээр орлогч, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Л.Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын

дарга, Д.Алтанцэцэг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал, У.Чинзориг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Технологийн албаны дарга.

Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулж, ажлын хэсгийг дахин хуралдуулах нь зүйтэй гэж үзсэн тул дээрх хуралдаанаас төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулах бөгөөд хуулийн төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулна.

Ж.Алдаржавхлан гишүүний микрофон.

Ж.Алдаржавхлан: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын гишүүдээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын дарга 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 74 тоот захирамжаар байгуулсан юм.

Ажлын хэсэг 2026 оны 3 дугаар сарын 27, 30, 31-ний өдрүүдэд тус тус хуралдсан.

Санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналаа Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.

Тус өдрийн хуралдаанаас ажлын хэсэг дахин хуралдаж, мөн Байнгын хорооны хуралдаанд гишүүдийн гаргасан зарим саналыг дахин ярилцах чиглэл өгсөн. Үүний дагуу ажлын хэсэг 2026 оны 4 сарын 07-ны өдөр хуралдаж, ажлын хэсэгт ирүүлсэн гишүүдийн саналыг дахин хэлэлцсэн.

Ингээд ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах өөрчлөлтийг төсөлд тусгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.Хуулийн төсөлд нэмж төсөл, арга хэмжээ нэмэхгүй байх.

Мөн хуулийн төсөлд тусгагдсан төслийн нэрийг өөрчлөхийг хориглох хаалтын зохицуулалт нэмж тусгах.

2.Төсөл, хөтөлбөрт тавигдсан шаардлага бүхий хэсгийг хуулийн төслийн зорилтот хэсэгт байх шаардлагагүй гэж үзэж, зорилтот хэсгээс тухайн дурдсан шаардлагуудыг хасах.

3.Цаашдаа хөгжлийн төсөл, хөтөлбөрийг Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх. Үүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох асуудлыг тусгах.

4.Зарчмын зөрүүтэй болон найрлагын шинжтэй саналуудыг ангилах зэрэг өөрчлөлтийг оруулсан болно.

Өмнөх ажлын хэсгийн хуралдаануудаар шийдвэрлэж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан асуудал болон 2026 оны 4 сарын 07-ны өдрийн хуралдаанаас шийдвэрлэсэн асуудлыг нэгтгэн бэлтгэсэн зарчмын зорилтот саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Н.Наранбаатар: Ж.Алдаржавхлан гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл 9 зүйлтэй.

Төслийг тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Д.Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Тийм. 1 дүгээр зүйл.

Ер нь энэ дээр “тайлбар” гэдэг хэсэг байгаа юм. “Гадаад зээллэг” гэдэг хэсгийг тайлбарлаж байна. Өрийн удирдлагын тухай хууль дээр “гадаад зээллэг” гэдэг нэр томъёо байхгүй. “Гадаад зээл” гэж байгаа. Зээллэгийг тусад нь заасан байгаа юм.

Тэгэхээр энэ хоёр төсөл дээр уг нь “гадаад зээл” л ашиглаж байгаа.

Тэгэхээр “зээллэг” гэдэг өрийн хэрэгсэл ашиглахгүй байгаа учраас үүнийг уг нь хасъя гэдэг. Энэ “зээл”, “зээллэг” гэдэг нэр томъёог өөрчилъе гэдэг санал Р.Батболд гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн бид хэд гаргасан боловч ажлын хэсэг дээр дэмжигдээгүй.

Энэ асуудал дэмжигдээгүйтэй холбогдуулаад хэрвээ энэ “зээллэг” гээд явбал “гадаад зээллэг” гэдэг нэр томъёо байхгүй. “Зээллэг” гэдэг агуулгаар явбал энэ нь Засгийн газрын баталгаанаас бусад гэж байгаа юм.

Тэгэхээр энэ явж байгаа хоёр төсөл дээр Засгийн газрын баталгаа нэмж үүсэх, гаргах нөхцөл үүсэх тийм зүйл байх уу, үгүй юу? Хэрвээ тийм нөхцөл үүсэхээр бол “зээллэг” гээд яввал тэр өрийн хэрэгслийг ашиглах бололцоогүй болж байгаа юм.

Тэгэхээр энэ талаар нэг тайлбар хийж өгөөч.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Алдаржавхлан: Бид ажлын хэсэг дээр ярьсан.

Энэ хууль угаасаа хоёр төслийг зохицуулж байгаа хууль шүү дээ. Төслийг бүр оноож хэлээд энэ хоёр төсөл хэрэгжиж дууссанаараа энэ хууль дуусгавар болно гэсэн байгаа учраас одоо өөр зүйлүүд орох бололцоо байхгүй гэж бид үзэж байгаа юм.

Тийм учраас зээллэгийн асуудлаар үлдээсэн байгаа.

Н.Наранбаатар: Д.Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Төсөлтэй холбоотой заалт ард байгаа учраас түүнтэй холбоотой асуудал яриагүй байна.

Өрийн тухай хууль дээр “гадаад зээл” гэдгийг тодорхой заасан байгаа байхгүй юу. Энэ хоёр төсөл маань гадаад зээлээр санхүүжүүлэх. Өөрөөр хэлбэл “гадаад зээл” гэдэг нь Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдээс олгосон өр үүсэх хөрөнгийн эх үүсвэрийг хэлнэ гээд. Энэ маш тов тодорхой заасан байгаа ийм харилцаа байгаа юмыг заавал будилаантуулж “зээллэг” гэдэг, “гадаад зээллэг” гэж оруулах шаардлага байхгүй харагдаад байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг үү? Ажлын хэсгийн ахлагч Ж.Алдаржавхлан гишүүн хариулъя.

Ж.Алдаржавхлан: Бид бас ажлын хэсэг дээр Д.Энхтүвшин гишүүн санал гаргаад олон талаас нь ярилцсан. Тэгээд ингэж ажлын хэсэг шийдсэн.

Тэгэхээр би саналаа хураагаад явах нь зүйтэй гэж үзэж байна.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүн нэрээ татсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналыг хураахын өмнө Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар дэмжигдсэн ажлын хэсгээс гаргасан хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн талаарх саналыг хүчингүй болгох саналыг гаргаж байна.

Ажлын хэсэг дахин хуралдсанаар дээрх санал агуулгын хувьд өөрчлөгдсөн байна.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “**Хуулийн зорилт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, тус зүйлийн өмнө “**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**” гэсэн агуулгатай **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “аюулгүй байдлыг хангах” гэсний дараа “бодлогын хүрээнд хэрэгжих” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, авто замын түгжрэлийг бууруулах” гэснийг хасаж, мөн зүйлийн “зорилго” гэснийг “зорилт” гэж, “санхүүжилтийн ашиглалтыг” гэснийг “гадаадын зээллэгийн ашиглалтыг” гэж, “зориулан эрх зүйн таатай орчныг” гэснийг “зориулсан эрх зүйн орчныг” гэж тус тус өөрчлөх.

Энэ саналыг хүчингүй болгох болгоё. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналаараа санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалт. /алх цохив/

15 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 86.7 хувийн саналаар өмнөх санал хүчингүй боллоо.

Одоо ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “**Хуулийн зорилт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, тус зүйлийн өмнө “**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**” гэсэн агуулгатай **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “аюулгүй байдлыг хангах” гэсний дараа “бодлогын хүрээнд хэрэгжих” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “санхүүжилтийн ашиглалтыг” гэснийг “гадаад зээллэгийн ашиглалтыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, З.Мэндсайхан, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Хосбаяр, Д.Энхтуяа. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. /алх цохив/

15 гишүүнээс 12 дэмжиж, 80.0 хувиар дэмжигдлээ.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан” гэснийг хасах.

Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн санал байна.

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “**Хуулийн үйлчлэх хүрээ**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “болон гадаад зээллэгийн эх үүсвэрийн урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагатай холбогдсон харилцааг” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “зээллэгийн санхүүжилтийн ашиглалт” гэснийг “зээллэгийн ашиглалт” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Ц.Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Тийм. Энэ дээр бас ингээд “зээллэгийн ашиглалт” болоод байгаа юм.

Би бол энэ гадаад “зээлийн ашиглалт” байна. Энэ хоёр төсөл чинь хоёулаа нэг нь Хятадын зээл, нэг нь Энэтхэгийн зээл байгаа байхгүй юу. Энэ чинь бонд, вексель гаргаж байгаа юм биш. Тэгээд дараа нь үүнийгээ гуравны хоёроор өөрчлөх юм болох гээд байгаа юм биш үү?

Тэгэхээр харин одоо үүнийгээ шууд өөрчлөөд явах ёстой л байсан байх даа л гэж би бодоод байх юм.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ж.Алдаржавхлан гишүүн саналыг тайлбарлаж үг хэлье.

Ж.Алдаржавхлан: Ер нь ажлын хэсэг шийдсэн учраас одоо ажлын хэсгийн саналыг энд өөрчлөх бололцоо байхгүй.

Тэгэхээр үүгээр хураагаад явахаас өөр арга байхгүй. Зээллэг гэхэд ч айхтар хууль зөрчих юм байхгүй байх гэж бодож байгаа.

Н.Наранбаатар: Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

4.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг “2.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.” гэсэн агуулгатай 3.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

5.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“2.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 80.0 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Р.Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Үг ч хэлүүлэхгүй явчихлаа. Хөөе. Өчигдөр яах вэ, нөгөө ажлын хэсэг дээр наадхыг чинь яриад ганцаараа болсон юм. Зургаа, долуулаа санал хураагаад.

Одоо бид их тэнэг юм батлах гээд байгаа байхгүй юу. Тэртээ тэргүй бондоор санхүүжиж байгаа юм нь байхгүй болсон мөртлөө “зээллэг” гэдэг үг хэллэгээ ашиглаад явах гээд байгаа байхгүй юу.

Зүгээр “гадаад зээлийн” болгохоор яах гээд байгаа юм бэ гэдгийг нь би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Тэр үгийг зүгээр “гадаад зээлийн” гээд явуулчхаач ээ гээд хэлээд барахгүй байгаа юм.

“Гадаад зээл” гэдэг нэр томъёолол байгаа болохоос биш “гадаад зээллэг” гэдэг нэр томъёо байхгүй байгаа байхгүй юу. Үгүй байхгүй. “Зээллэг” гэдэг үг бол байгаа. Зүгээр “гадаад зээллэг” гэдэг юм нь хаана байгаа юм. Мэдэхгүй. Би тэрийг нь олж харахгүй байгаа юм.

Тэгэхээр наад хууль чинь өөрөө явахаараа ийм нэр нь хүртэл. Үгүй ээ, үгүй. Багтаж байгаа. Тэгэхдээ “гадаад зээллэг” гэж байхгүй байхгүй юу даа. Алдараа гишүүн ээ. Би хэлээд байгаа шүү дээ. “Гадаад зээл” гэж байна. Тийм. “Гадаад зээллэг” гэдэг нэр томъёо байхгүй байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Гишүүн асуулт асуусан учраас. Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг.

Ж.Алдаржавхлан: Яах вэ, Сангийн яам нэмж болно.

Энэ зээллэг дотор ажлын хэсэг дээр яриад санал хураасан учраас одоо энэ өөрчлөх бололцоо байхгүй. Тэгээд “зээллэг” дотор “зээл” багтаж байгаа гэж бид ойлгож байгаа. Яагаад заавал “зээл” болгох гээд байгаа Р.Батболд гишүүний саналыг би ойлгохгүй байгаа юм. Яагаад тэгээд зүтгээд байгаа юм.

Н.Наранбаатар: Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг.

Ж.Алдаржавхлан: Бид зөндөө ярилцсан шүү дээ. Ажлын хэсэг дээрээ.

Байнгын хороон дээр орж ирж юу яагаад байна. Дэд ажлын хэсгээс тайлбар авъя. Индрийн микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Өрийн удирдлагын хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр “өрийн хэрэгсэл” гэж “бүх өр үүсгэж байгаа зүйлээ” хэлж байгаа юм.

Үүний дараа арай жижгэрч байгаа нь “зээллэг” гэж байгаа юм.

- “Зээллэг” дотор –
 - “бонд” нь ч байж байгаа,
 - “зээл” нь ч байж байгаа. Ийм асуудал байгаа.

Тэгэхээр “зээллэг” гээд нэрлэсэн тохиолдолд дотор нь хууль дээрээ яг хоёр төслөө нэрлээд бичиж байгаа тохиолдолд ингээд л үүгээрээ хязгаарлана л гэдэг агуулга.

Утга агуулгын хувьд болон үзэл санааны хувьд тийм зарчмын өөрчлөлт гарахгүй гэж.

“Гадаад зээллэг” гэдэг үг Өрийн удирдлагын хууль дээр байгаа. 16 заалт дээр байна. “Гадаад зээллэг” гэсэн ойлголт. Тийм.

- “Гадаад зээл” гэж байна,
- “Гадаад зээллэг” гэж байна. Тийм.

Хууль дээрээ хоёр төслөө л нэрлэж байгаа учраас яг тэрүүгээрээ хүрээ хязгаар маань хязгаарлагдсан учраас энэ нь өргөн хүрээгээрээ нэр нь болно гэсэн санаа.

Н.Наранбаатар: Ажлын хэсгээс нэмж тайлбар өгөх үү? Ж.Алдаржавхлан нэмж тайлбар өгөх үү?

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

7.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. /алх цохив/

14 гишүүн дэмжиж, 93.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад санал хураалтыг алгасаад явсан байна. Сая 5-ыг хураасан. Одоо 4-ийг хураана.

6.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг “3 дугаар зүйл” болгож, тус зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын зардал**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, НЭГДСЭН ТӨСӨВ ХООРОНДЫН ХАМААРАЛ**” гэсэн агуулгатай **ХОЁРДУГААР БҮЛЭГ**-ийн нэр тус тус нэмж, мөн зүйлийн “нийт зарлага” гэснийг “нийт зарлагын дээд хэмжээ” гэж, “санхүүжилтийн ашиглалтын зардал, түүний зардлын өсөлтөөр” гэснийг “тухайн жилийн ашиглалтын зардлын өсөлтөөр” гэж тус тус өөрчилж, “Тухайн жилийн” гэснийг хасах.

Санал хураалт. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Нэр нь юу гэсэн агуулгатай байсныг өөрчилсөн гэж нэгдүгээрт.

Ер нь байна шүү дээ. Би ойлголоо л доо. Зээллэгт бондыг оруулья л гээд байгаа юм байна. Тийм ээ. Тэгэхдээ энэ чинь өрийн тухай хуулиараа миний байсан үе хэвээрээ л юм байна шүү дээ. “Гадаад зээллэг”, “гадаад зээл” хоёр чинь хоёулаа өөр тодорхойлолттой хэвээрээ л байгаа юм байна шүү дээ.

Тийм учраас нэг нь нэгэндээ багтана гэж тайлбарлах чинь учир дутагдалтай л юм байна.

Би юу хэлээд байгаа вэ гэвэл та нар зөрчилтэй хууль битгий гаргачхаарай. Тэгээд дараа нь гуравны хоёроор санал хураалт явбал нөгөөдөх нь явахгүй болоод бүтэлгүйтээд ингээд хоёрын хооронд “зээл” гэж үг нэмж чадахгүйгээсээ болоод хууль чинь зөрчилтэй вий дээ л гэж хэлээд байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 80.0 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга. /алх цохив/

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга. /алх цохив/

Ц.Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Одоо энэ 6 дээр бүр тодорхой байж байна шүү дээ.

“Гадаад зээлийн санхүүжилтийг” гэснийг “гадаад зээллэгийн” гэж өөрчилье гэж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ чинь яг гарахаараа асуудал үүсгэх гээд байна шүү дээ. “Гадаад зээл” чинь өөр юм гэх гээд байна шүү дээ. Бүгдээрээ л өр үүсгэж байгаа хэрэгслүүд мөн үү мөн. Тэгэхдээ “гадаад зээллэг” нь нэг тодорхойлолтоор байна. “Гадаад зээл” нь өөр нэг тодорхойлолтоор байна.

Тэгэхээр наадах чинь гадаад зээлээ хасчхаад байна шүү дээ.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Сангийн яам тайлбар хийе.

Н.Наранбаатар: Сангийн яам. Индрийн микрофон дээр очоод тайлбар хийгээрэй.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Энэ “гадаад зээллэг” болохоор яг анхдагч хуулийн яг нэршлийн асуудал байгаа гэж харж байгаа.

Өрийн удирдлагын хуулийн 4.1.2, 4.1.14, 4.1.15 дээр 4.1.11 дээр өрийн үйлчилгээний асуудал. Уучлаарай. 4.1.2 дээр өрийн хэрэгсэл гэж юу вэ гэдгээ заасан.

Энд нь “гадаад зээл”, “үнэт цаас” хоёр байгаа. Өрийн хэрэгсэл.

4.1.15 дээр “зээллэг” гэдэг дээрээ өрийн баталгаанаас бусад хэрэгсэл гээд буцаад өрийн үйлчилгээн дээр очиж байгаа.

Тэгэхээр анхны хууль санаачилсан асуудал нь энэ хоёр нэр томъёо буюу эх үүсвэрээсээ хамаараад нэршлийн хувьд “гадаад зээллэг” гэдэг нэр томъёогоор явсан. Одоо яг өөрчлөлт орж байгаа тохиолдолд яг зээллэгээр явах уу, зээлээр явах уу гэдэг асуудал байгаа байх.

Тэгэхдээ гадаад зээллэгээр явахад гадаад зээл нь өөрөө энэ дотор яг томъёоллоор орчхож байгаа учраас бидний хувьд асуудалгүй гэж харж байна.

Н.Наранбаатар: Санал хураалт. /алх цохив/

Саналын томъёоллыг уншаагүй учраас санал хураалтыг хүчингүй болгоё. Томъёоллыг уншиж танилцуулъя.

8.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийг “3.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “гадаад зээлийн санхүүжилтийн” гэснийг “гадаад зээллэгийн” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга. /алх цохив/ Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

9.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийг “3.3” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “энэ хуулийн 3.3-т заасан” гэснийг “гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “болон энэ хуулийн 3.1-д заасан хязгаар” гэж нэмж, “санхүүжилтийн” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсгийн санал байна.

10.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчилж, мөн зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын ил тод байдал, хяналт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ**” гэсэн агуулгатай **ГУРАВДУГААР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “тухайн жилийн” гэсний дараа “нэгдсэн” гэж тус тус нэмж, “хагас жил тутам” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 73.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Д.Энхтүвшин гишүүн асуулттай. Д.Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: 9 чинь нөгөө юутай холбоотой юм байна. Тийм ээ. Би тэгвэл андуурсан байна. Уучлаарай.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

11.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийг “4.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “төслийн ашиглалттай” гэснийг “зээллэгийн ашиглалттай” гэж, “журмын” гэснийг “хууль тогтоомжийн” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 73.3 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу төсөлд бусад зүйл гэсэн 4 дүгээр бүлэг. Шинээр нэмэгдэж байгаа зүйлээр санал хураалт явуулна.

Энэ дээр ажлын хэсгийн саналтай.

12.Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай бүлэг нэмэх:

“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

5.1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтад 2026 оны төсвийн жилд санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан үйлчлэлд хамруулна.

5.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүй болгоё. Ц.Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Энэ дээр Та хэд нөгөө өрийн хязгаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа заалтуудыг зохицуулсан байгаа юу гэдгийг л би асуух гээд байна.

Нөгөө талаар байна шүү дээ. Ажлын хэсгийн саналыг өөрчилж болно. бас. Тэрийг бид боломж байгааг анхаараарай. Яагаад гэвэл зарчмын зөрүүтэй санал гаргах уу гэж асууж байхад бид хэрвээ зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгах юм бол тэр хураагдаад, тэр санал дэмжигдвэл тэр саналаар явна.

Тийм учраас ажлын хэсгийн саналыг бид өөрчилж болно. Дэмжсэн санал нь үлддэг. Тийм ээ. Зарчмын зөрүүтэй санал яг үүгээр гаргах юм бол. Тийм.

Тийм учраас тийм боломж байгаа. Энэ дээр би нэг хариулт аваадахъя. Яг тэр Төсвийн тогтвортой байдлын хуулийнхаа заалтуудыг хэр зохицуулсан бэ гэж.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Сангийн яам тайлбар хийнэ. Саналаа тайлбарлая.

Н.Наранбаатар: Сангийн яам хариулъя. Индрийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Тэгэхээр саяын санал дээр гадаад зээлийн яг энэ ашиглалтын хэмжээ 2026 оны төсвийн тухай хууль дээр батлагдсан байгаа. Нийт энэ жил ашиглах буюу гадаад зээлээс авч өрд тооцогдох дүн 1.2 их наяд байгаа.

Тэгэхээр 2026 оны төсвийн хууль маань яг хэрэгжилт нь эхэлсэн явж байгаа учраас хууль дээр батлагдсан дүн маань энэ хоёр төслийн гадаад зээлийн ашиглалт талдаа нэмж гарахаар ийм санал байгаа.

Бусад өр дээр болон тайлан бүртгэл яг хэвээрээ хуучнаараа явна гэсэн. Одоо явж байгаа процессоороо явна гэсэн үг.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Нөгөө хоёр төсөл чинь 2026 ондоо дуусахгүй шүү дээ. 2027 оны, 2028 оны гээд л Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдэл, өрийн хязгаарын дээд хэмжээ гээд л энэ бүгд тэр чинь орж ирээд байна шүү дээ.

- Түүнтэйгээ яаж зохицуулсан бэ?
- Өрийн дээд хязгаарыг давбал яаж юм бэ?
- Давахгүй байхаар байгаа юм уу?

-гэж асуугаад байхгүй юу.

Н.Наранбаатар: Индрийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Хуулийн хувьд хуулийн төслийн одоо яг өөрчлөлтөөр 3.2 дээр энэ төслүүд хэрэгжиж дуусах хугацаанд тухайн жил жилийнхээ төсөв дээр батлагдсан зээлийн ашиглалтаар энэ хоёр төслийн зардлаар нэмэгдэхээр зохицуулалт байгаа.

Энэ заалтын хувьд яг 2026 оны төсөв өөрөө хэрэгжээд хэрэгжилт нь дунд орсон байгаа учраас тусгайлан дагаж мөрдөх журам дээр нэмж оруулж байгаа.

Өрийн хувьд угаасаа гадаад зээл өрийн хязгаараа тооцоод хэлэлцээрүүд батлагдаад ашигласан дүнгээрээ өрд бичигдэж байгаа.

Мөн ашигласан дүн дээрээ хүүгийн зардал гарна. Хүүгийн зардал өр дээр тооцогдох асуудал одоо байгаа яг Тогтвортой байдлын хууль, Төсвийн хуулиараа явна.

Н.Наранбаатар: Санал хураалт. /алх цохив/

13 гишүүн дэмжиж, 86.7 хувиар дэмжигдлээ.

13 дахь санал хураалт. **13.**Хуулийн төсөлд шинээр нэмэх 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.Дунд хугацаанд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хөгжлийн түнш орнуудын санхүүжилтээр хэрэгжих, төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж болох бөгөөд төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар өрийн баталгаа гаргаж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт тодруулга. Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ заалт. Ямар ч хэрэггүй заалт харагдаж байна. Энэ дотор харахаар өөрөөр хэлбэл энэ хоёр төсөл маань ойлгомжтой байхад ийм ийм төслүүд гээд дахиад шинэ төсөл оруулж ирэх агуулгатай заалт эндээс үнэртээд байгаа байхгүй юу.

Тэгэхдээ нөгөө талд нь бид хэд шинээр оруулж ирэхгүй гэдгийг нь хаасан байгаа. Тэгэнгүүт энд “зээллэг” гэдэг нэр томъёоны чинь алдаа нь энд гарч ирж байна.

“Зээллэг” гэдэг чинь Өрийн тухай хуулийн 4.1.15 дээр “Засгийн газрын өрийн баталгаанаас бусад өрийн хэрэгслээр дамжуулан өр үүсгэх” гэдгийг. Гэтэл энэ заалт дээрээ “Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно.” гээд.

Засгийн газрын өрийн баталгаа гаргахгүй гэдэг нэртэй хууль дотроо Засгийн газрын өрийн баталгаа гаргана гэдэг тийм агуулга оруулсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол нэгдүгээрт шаардлагагүй.

Хоёрдугаарт, зарчмын хувьд хоорондоо зөрчилдсөн заалт байгаа учраас үүнийг бараг татаад авсан нь дээр байх гэж бодож байна.

Н.Наранбаатар: Хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Ж.Алдаржавхлан: Манай Сангийн яам хариулчих.

Н.Наранбаатар: Сангийн яам. Хэн нь хариулах вэ? Ажлын хэсэг дээр санал хураалт явуулсан юм чинь ажлын хэсгийн ахлагч хариулсан нь зөв байх аа.

Ж.Алдаржавхлан: Үгүй ээ, үгүй яах вэ, энэ зүгээр бид ярилцаад оруулсан, ажлын хэсэг дээр ярьж байгаад оруулсан санал л даа.

Одоо гадаад зээл ашиглалтын асуудал чинь зөвхөн төсөв дээр явж байгаа. Цаашдаа бид Хөгжлийн банкаар гадаад зээл ашиглалтыг дамжуулан санхүүжүүлэх боломжийг нь нээж өгөх зорилгоор энэ заалтыг л оруулсан юм.

Байнгын хорооны гишүүдээс шаардлагагүй гэвэл хасаж болно. Санал хураагаад л шийдье. Өөр арга байхгүй.

Н.Наранбаатар: Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Үгүй. Энэ харин чухал гэж бодоод байгаа байхгүй юу.

Гэтэл би түрүүн хэлээд байгаа шүү дээ. Та нар “гадаад зээл ашиглалтын” гэхээр чинь бонд гаргахыг байхгүй болгоод хаячхаад байгаа байхгүй юу. Тэгээд би тэр “зээл, “зээллэгийн” гэдгийг нь оруулаад явъя гэж.

Би яагаад энэ заалтыг дэмжээд байгаа вэ гэхээр байна шүү дээ. Анх Хөгжлийн банкиг байгуулахдаа нэн шаардлагатай улс орны хөгжилд хувь нэмэр оруулах томоохон дэд бүтцийн төслүүдийг төсвөөс гадуур санхүүжүүлж явъя гэдэг агуулгаар Хөгжлийн банк байгуулагдсан байхгүй юу.

Уг нь тэгж төсвийн хязгааруудад баригдаж байхын оронд бид Хөгжлийн банкаараа явах нь зөв байгаа байхгүй юу. Тэгж байгуулчхаад манай байгуулсан нөхдүүд нь эргээд хоёр төсөвтэй боллоо гээд үүнийгээ унагаад хаясан байхгүй юу. Хоёр төсөвтэй болж байна гээд.

Уг нь энэ томоохон ийм төслүүдийн шаардлагатай санхүүжилтийн асуудлыг бид Хөгжлийн банкаараа дамжуулаад л гаргаад явдаг нь хамгийн зөв зам. Төсвөөс гадуур ингээд явах нь зөв.

Н.Наранбаатар: Дахиад 1 минут өгье. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, зөв. Ж.Алдаржавхлан.

Тэгсэн мөртлөө чи хуулийнхаа нэр томъёогоор “зээллэгийн” гэдгээрээ хаасан байхгүй юу. Тэгээд чи хаасан мөртлөө энд өрийн баталгааны тухай юмыг оруулж болохгүй шүү дээ. Биш ээ. Ингэсэн шүү дээ. Өрийн баталгаа орохгүй гэсэн шүү дээ.

Н.Наранбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Ер нь том төслүүдийг Хөгжлийн банкаараа санхүүжүүлээд явах ёстой. Цаашдаа. Заавал төсөв дээр тавьж хязгаарт багтааж хэлэлцэхгүй байна гэдэгтэй санал нэг байгаа юм. Ер нь цаашдаа тэр зарчим нь зөв.

Харин ч сая “зээл” биш “зээллэг” гэдэг үг, үсэг байх ёстой гэж оруулж ирээд байгаагийн гол утга учир чинь одоо л яг энэ заалт дээр гарч ирж байна л даа.

Тэгэхээр яах вэ, энд бас цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой тодорхой асуудлууд үүсвэл боломжийг нь нээгээд явъя гэсэн санаа л юм байна.

Тэгэхээр нэгэнт “зээллэг” гэж орж байгаа бол энэ заалтаа дэмжээд хамтад нь агуулгаар нь аваад явах нь зөв юм байна л гэж харж байна. “Зээллэг” гэхээр яг таарч л байгаа юм л даа. Хэрвээ “зээл” байвал саяын заалт чинь зөрнө гэсэн үг. “Зээллэг” учраас орж байна гэсэн үг. Тийм.

Н.Наранбаатар: Б.Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Одоо яг юмнууд жоохон тодорч байна шүү дээ. Хүүе. Энэ хоёр дахь удаагаа хэлэлцэж байгаа биз дээ. Хүмүүс ээ. Хүүе. Ц.Даваасүрэн гишүүн ээ. Тийм.

Тэгэхээр ийм байна. Ер нь анхнаасаа “зээл” үү, “зээллэг” үү гэдэг дээр хариулт ирэхгүй байгаад байсан. Тийм ээ. Аяндаа энэ 5.4-өөр илүү тодорч байна шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол яагаад “зээллэг” вэ гэхээр.

Ц.Даваасүрэн гишүүн ээ. би яриадахъя. Тийм. Засгийн газрын баталгааг оруулахгүй зорилготойгоор явсан гэдгээ анхнаасаа хэлэх ёстой байхгүй юу. Ордоггүй учраас “зээл” гээд. Тэгээд оруулмааргүй байгаа шүү.

Үүнийг Сангийн яам бүх төсөвтэй холбоотой гадаад зээл, зээллэгтэй холбоотой дата байгаа. Сангийн яамны саналыг сонсох нь тун чухал.

Тэгэхээр энэ 5.4-ийг хасах саналтай байна шүү. Ороод ирэхээрээ анхны энэ хуулийн төслийг дэмжих хүмүүс ухарна гэсэн үг. Хэрвээ энэ орвол ухарна гэсэн үг шүү дээ.

Н.Наранбаатар: Санал хураалт. Д.Энхтүвшин гишүүн ээ, санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

14.Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололтой уялдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 80.0 хувиар дэмжигдлээ.

15.Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зориулан эрх зүйн таатай орчныг” гэснийг “зориулсан эрх зүйн орчныг” гэж, “зорилго” гэснийг “зорилт” гэж, 2 дугаар зүйлийн “Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн” гэснийг “Энэ хуулийн 2.2-т заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн” гэж, “зохицуулах ба энд зааснаас” гэснийг “энэ хуулиар зохицуулах ба энэ хуульд зааснаас” гэж, төслийн 4 дүгээр зүйлийн “үл хамаарна” гэснийг “хамаарахгүй” гэж, төслийн 7 дугаар зүйлийн “санхүүжих зардал” гэснийг “санхүүжүүлэх зарлага” гэж, “нөхцөлд” гэснийг “тохиолдолд” гэж тус тус өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн “төслийн” гэсний өмнөх болон 6 дугаар зүйлийн “нийт” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 73.3 хувиар дэмжигдлээ.

Гадаад зээллэгийн үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх. Гишүүд байж байгаарай. Дахиад нэг асуудал байгаа. Явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Чуулган дээр. Ж.Алдаржавхлан гишүүн танилцуулчих. Тийм. Сайд болох юм болов уу. Нээрээ.

Чуулган дээр танилцуулах танилцуулах саналтай гишүүн байна уу?

Д.Үүрийнтуяа гишүүн танилцуулна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Дөрөв.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн
биелэлтийн тайлан**

Дөрөв дэх асуудал руу оръё. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд Засгийн газраас хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан Улсын Их Хуралд ирүүлнэ гэж.

Уг тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр заасны дагуу Засгийн газраас хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг ирүүлснийг Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хүрээнд хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.2-т заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт, хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж ирүүлснийг Та бүхэнд тараасан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Ч.Бат-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, И.Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баярмагнай Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Ерөнхий газрын дарга, Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга, Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Х.Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацийн газрын дарга, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Л.Наранчимэг “Эрдэнэс Монгол” компанийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Л.Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал.

Улсын Их Хурлын Тамгын газраас Г.Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх, Ц.Лхагвагэрэл Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт.

Засгийн газраас ирүүлсэн Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн

талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгөөрэй.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хамаарах 44 шийдвэрийн 326 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Хяналт шинжилгээ үнэлгээг Засгийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээний мэдээллийн санд ирүүлсэн тайлан, мэдээллийн их өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайланд нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын мерит төсөл, ЮНИСЕФ, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг зөвлөмж, саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатны оролцоог хангасан арга хэмжээ болсон.

Мөн ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзсэн болно.

2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд –

- нийт 134 хуулийн 540 заалтыг давхардсан тоогоор 895 байгууллага,
 - Улсын Их Хурлын 158 тогтоолын 861 заалтыг давхардсан тоогоор 1992 байгууллага,
 - Улсын Их Хурлын Байнгын хорооны 100 тогтоолын 587 заалтыг давхардсан тоогоор 1660 байгууллага –
- хэрэгжүүлэн ажилласан бүртгэлтэй байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 44 шийдвэрийн 326 заалтыг яам, агентлаг, аймаг, нийслэлд хэрэгжүүлж ажилласан нь 74.7 хувьтай байна.

- Нийт 165 заалт хэрэгжсэн.
- 130 заалт хэрэгжих шатанд байна.

Үүнээс удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 33 заалт, хэрэгжээгүй 30 заалт байгаагаас 29 нь удирдлага зохион байгуулалтаас, 1 нь санхүү хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

Хугацаатай өгөгдсөн, оны төгсгөлд гарсан буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 7 заалт байна.

Мөн хэрэгжүүлэх хугацаа, чиг үүрэг тодорхойгүй, зардал, санхүүгийн эх үүсвэр, хийх ажил, зорилго тодорхойгүй, хэмжигдэхүйц биш байдлаас үүдэн 7 шийдвэр хэрэгжих боломжгүйгээр дүгнэгдсэн байна.

2025 оны жилийн эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 165 заалтыг Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаас хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Тайлан онд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэж байна. Тухайлбал,

- төрийн байгууллагын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдэж чадаагүй,
- салбар хоорондын ажлын уялдаа сул,
- олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгддэг,
- төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй,
- бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал –

-зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах хрга хэмжээ авахыг даалгасан. Үүнд:

- ▶ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх.
- ▶ Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах.
- ▶ Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа

зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх.

- ▶ Санхүүгийн эх үүсвэрийг тусгах.
- ▶ Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах.
- ▶ Дижитал хяналт, их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх.
- ▶ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулалт танилцуулах.

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан болно.

Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого буюу 1996 оны 38 дугаар тогтоолыг эргэн харах, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байна.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах дараах асуудлууд байна.

- Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар олгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэлийн байгууллагуудын түвшинд уялдуулах, нэгдсэн байдлаар тайлагнах боломжийг бүрдүүлэх.
- Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сантай уялдуулах, гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах, Улсын Их Хурлын Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутамд танилцах боломжтой болох.
- Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах.
- Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хороодын шийдвэр Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол

хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д “Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хурал ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.” гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байгаа тул хугацааг уян хатан байдлаар зохицуулах зэрэг болно.

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт 326 заалтын –

- 0.6 хувь нь хуулиар ногдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн заалт,
- 35.9 хувь нь тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт,
- 6.7 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолцол бүхий заалт тус тус эзэлж байна.

Цаашид Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгох, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахаар зорьж байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно. Баярлалаа.

Н.Наранбаатар: Б.Энхбаяр сайдад Баярлалаа.

Тайлантай холбогдуулан ажлын хэсгээс асуух асуулттай гишүүн байна уу? Нэрсээ өгье.

П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: 11 Байнгын хороогоор нэг ийм үр дүнгүй хурлууд явж байна.

Энэ дээрээс нэг их шийдээд, асуудлыг яг ингэж шийдэх юм байна гээд анхаараад байгаа зүйл ерөөсөө алга.

Ямар ч байсан эхлээд уг нь хуулиудын зүйл, заалт, журам зөвлөл баталсан уу гэдэг байдлыг баталсан, батлаагүйгээ тайлагнаж байхындаа оронд энэ хуулийн үр нөлөө нийгэмд хэрхэн нөлөөлж байна вэ гэдэг асуудал дээр тайлагнаж байх ёстой юм.

Сангийн яамнаас асууя. Төрийн хэмнэлтийн хууль ер нь зорилго, ач холбогдолтой хүрсэн үү?

Анхны хуулийн төслийг боловсруулж байх тэр үзэл баримтлалтай яг нийцэж явж байна уу? Үүнийг хэлээч.

Тендерийн хууль хэн найруулах юм. Бүү мэд. Энэ тендер худалдан авалтын хууль чинь өөрөө Монгол Улсын төсвийг 6-хан сарын настай болгочоод байгаа шүү. Наад төрийн хэмнэлтийн хууль хоёр чинь.

Бид энд Улсын Их Хурал төсөв батлаад, хууль батлаад, хөрөнгө оруулалтуудыг баталж байхад Төрийн хэмнэлтийн хууль болон Тендерийн хуулиараа 5 сарын 31-нээр бүх хөрөнгийг нь хураагаад авчхаж байгаа байхгүй юу.

Ингэж Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхэд халдаж болж байгаа юм уу? Улсын Их Хурлын бүрэн эрхэд.

Тэгэхээр ийм хуулийн мөн чанар буюу энэ суурь Үндсэн хуулиараа олгогдсон төсөв батлах ёстой Улсын Их Хурлынхаа зүйлүүдийг ийм хуулиуд батлах замаар зогсоодог. Улсын Их Хурал нь шийдвэр гаргах ямар ч бололцоогүй болгодог. Нөгөө талдаа үүнийг зүгээр төсвийн сахилга бат гэж байгаа боловч энэ чинь мөн чанарын хувьд Үндсэн хуулийнхаа тэр заалт руу халдаж байгаа байхгүй юу. Энэ дээр юу гэж бодож байна? Үүнийг нэг хариулж өгөөч.

Хоёрдугаарт, Б.Энхбаяр сайд хэр тогтвортой ажиллахыг нь мэдэхгүй байна. Одоо бас ингээд сайдууд солигдоод байгаа учраас хэлэхээр дараа улиралд тайлагнаж байгаа хүн нь өөрчлөгддөг юм байна.

Одоо ингээд түрүү жил чинь бараг Ерөнхий сайд маань өөрөө байсан юм уу даа. Тэгээд ингээд дундуур нь С.Бямбацогт сайд, одоо ингээд Б.Энхбаяр сайд.

Хэдүүлээ арга барилаа нэг жоохон өөрчилье л гэж бодож байна.

Уг нь энэ хуулиудын зөрчилдөөн байхгүй юм байгаа юм. 700, 800 хуулийн заалт хоорондоо зөрчилдөөд байна гээд бид нийгэмд мессеж өгөөд байгаа боловч хууль зүйн техник, шинжлэх ухаан талаасаа хуулийн эрэмбийг зөв тогтоовол зөрчилдөх хуулийн текст маш бага байгаа.

Бид хэд хуулийг эрэмбийг нь тогтоож хэрэглэдэггүй. Бүх хуулиудыг зэрэгцүүлж аваачаад нэг голдирлоор явах ёстой, нэг тексттэй байх ёстой гэдэг явж байгаа учраас зөрчилдөөн гэдэг зүйлийг хэллээ.

Наад хиймэл оюун ухаанууд чинь үүнийг мэдрүүлж гэдэг юм уу, хөгжүүлэлтээ хийгээгүй учраас автоматаар гаргаж ирээд байгаа юм.

Одоо энэ юмнуудаа жоохон учир жанцандаа гаргаач ээ. Энэ нь өөрөө гадна талдаа асар буруу мэдээлэл байхгүй юу. Хөрөнгө оруулагч нарт. Ийм их хуулийн зөрчилдөөнтэй улс оронд чинь хөрөнгө оруулалт хийнэ гэж ярих уу?

Тэгээд үүнийг хууль зүйн техник талаас нь шийдэх ёстой газрууд нь хүртэл юм дуугарахгүй яваад байхаар Монгол Улсын хууль чинь тэр чигтээ зөрчилтэй юм байна гэж хараад байгаа байхгүй юу.

▷ **Ерөнхий хууль** хамгийн суурь. Дараа нь үйлчилнэ.

▷ **Тухайлсан хууль** нэг удаагийн үйлчлэлтэй гээд бид хэд эрэмбээ тогтоовол зөрчилдөхгүй.

Үүнийг мэдэхгүй байгаа учраас хуулийн байгууллагууд хүртэл шийдвэр гаргасан албан хаагч... /минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье. П.Сайнзориг гишүүнд.

П.Сайнзориг: Хуулийн эрэмбийг зөв ойлгохгүй байгаа учраас энэ хуулийн байгууллага чинь хүртэл шийдвэр гаргасан албан хаагчдыг энэ хуулийг барьсангүй гэж шийтгэж болж байна. Эсвэл энэ хуулиар нь явахаар энэ хуулийг дагаж мөрдлөө гээд хийчхэж байгаа байхгүй юу.

Эрэмбийг зөв тогтоож чадвал ер нь маш олон зүйлүүд цэгцэрнэ шүү.

- Төрд шийдвэр гаргахаасаа болгоомжлох байдлууд цэгцэрнэ.
- Шийдвэр гаргалаа гээд хэн нэгнийг буруутгадаг, хэлмэгдүүлдэг байдал цэгцэрнэ.
- Төрийн үйл ажиллагаа шуурхай явна.

Тэгээд нийтлэг байдлаараа энэ асуудлыг бид ойлгохгүй бөөнөөрөө 700, 800 хууль зөрчилтэй гээд. Үүнийгээ AI-аар хийлээ гээд.

Би тэр AI-ийн программыг үзсэн. Ямар ч хуулийн мэдлэггүй хүмүүс хөгжүүлэлт хийгээд, тэгээд энэ асуудлыг хэлсэн чинь дахиж хөгжүүлэлтийг нэмж хийе гээд сууж байгаа байхгүй юу.

Тэр чинь “**BAT Solution**”. Уулзсан шүү дээ. Тэгээд бид хэд ийм зүйлүүдийг статистик болгоод энд тэнд яриад, одоо ингээд Монгол Улсын эрх зүйн тогтолцоогоо бүр сүйрүүлж байгаа байхгүй юу. Тэгээд яаж ажиллах ёстой юм бол доо.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Сангийн яам. Индрийн микрофонд очъё хариул. Индрийн микрофоныг өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 сарын 29-нд батлагдсан. Нийт 22 зүйл, заалттай. Үүнээс 2 дугаар бүлэг дээр байгаа 11 зүйл нь яг хэмнэлттэй холбоотой асуудал байгаа. Бусад нь эрх хэмжээ, хамрах хүрээ, агуулга, тэгээд хяналт тавих асуудлыг заасан байгаа.

11 зүйлийн ихэнх нь төсөв боловсруулах, батлахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байгаа.

Төсвийн харилцаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, тэгээд мэдээж хэрэг процессын хууль явж байгаа. Сангийн яамны хувьд энэ хэрэгтэй хууль гэж харж байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд угаасаа дүн шинжилгээ хийх хугацаа маань өөрөөсөө дөхөж байгаа.

Тэгэхээр энэ хууль цаашид хэрэгтэй, үгүй дээр дүгнэлт нь гарсны дараа бид энэ хуулийг яах вэ гэдэг асуудлыг ярих байх.

Тухайлан түрүүний ярьсан 5 сарын 31-ний асуудлаар хөрөнгө оруулалтыг зогсоож байгаа асуудал дээр бид яг хуулийн зөрчил талаас нь хариулах боломжгүй.

Сангийн яамны зүгээс төсөв талаас, үр ашиг талаас нь хариулах юм бол 5 сарын 31 гэхэд гэрээ хийгээгүй ажил маань өөрөө удаашрах, удааширч байгаа ажил маань өөрөө цаг хугацаандаа ашиглалтад орохгүйгээс болоод нийгмийн үр өгөөж нь буурах, төсвийн үр өгөөж нь буурах.

Хамгийн зовлонтой нэг зүйл байдаг маань төсөвт өртөг маань нэмэгдэх ийм үр нөлөөтэй байдаг.

Төсөвт өртөг нэмэгдэхээр яадаг вэ гэхээр одоогийн явж байгаа систем маань төрийн аудитын байгууллагаар бид төсөвт өртгөө шинэчлүүлээд, ингээд Улсын Их Хурал төсөвт өртгийн нэмэгдлийг оруулж ирдэг.

Энэ хооронд тухайн хувийн компани маань өөрөө хохирох ийм зүйлүүд байгаад байдаг.

Нөгөө талдаа уг нь хөрөнгө оруулалт маань өөрөө бэлтгэлээ хангагдсан байх ёстой, газартай байх ёстой, ТЭЗҮ-тэй байх ёстой. Бүх бэлтгэлээ хангагдсан байж байж зарлаж төсөв дээр тавигдах ёстой байтал энэ маань өөрөө бас яг тийм

төгс байдлаар хэрэгжиж чадахгүй байгаагаас энэ заалт тухайн үедээ орж байсан ийм заалт байгаа.

Тэгээд Хууль тогтоомжийн хуулийн яг энэ хугацаандаа бид хуулийн үнэлгээгээ хийгээд тэгээд хуулийг үргэлжлүүлэх үү, эсвэл хуулийн хувьд өөрчлөх заалтууд байна уу гэдэг дээр Засгийн газрын түвшинд яригдах байх гэж хэлье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Хариулт дутуу байна уу?

Би товчхон асуулт асууя. Хэрэгжээгүй заалтууд гээд 24 хэрэгжээгүй заалт гээд байна.

Манай Төсвийн байнгын хороотой холбогдох ажлууд байгаа.

- Энэ ямар ямар ажлууд байгаа юм?
- Яагаад хэрэгжих боломжгүй байгаа юм?
- Хэрэгжээгүй нь хэд байгаа юм?
- Хэрэгжих боломжгүй нь хэд байгаа юм?

- Тэгээд цаашдаа яах юм?
- Хэрэгжээгүйгээ хаях юм уу?
- Үргэлжлүүлээд цааш нь үүрэг чиглэл өгөх юм уу?
- Аль эсвэл хэрэгжүүлээгүй албан тушаалтан, хүмүүст нь хариуцлага тооцох юм уу?

Яах ёстой юм гэсэн нэг асуулт байна.

Ер нь нийтлэг энэ урд онуудаас 2025 оны хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлт чинь өсөж байгаа юм уу, улам дордоод яваад байгаа юм уу гэсэн харьцуулсан судалгаа байна уу гэсэн ийм хоёр асуулт байна.

Хэн хариулах вэ? Нэр, албан тушаалаа хэлээд индрийн микрофон дээр очоод хариулна.

Ч.Бат-Эрдэнэ: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ байна.

Гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам байгаа.

Энэ журмын хүрээнд бид бүхэн Засгийн газрын хуралдаанаар Улсын Их Хуралтай холбоотой Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороотой хорооны тогтоолын хэрэгжилтийн дүн мэдээг бид бүхэн хүргүүлсэн.

Энд бидний хүргүүлсэн тайлан мэдээнд 27 заалт хэрэгжээгүй гэсэн дүн мэдээтэй ирсэн.

Улсын Их Хурлын хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжээс 24 заалт хэрэгжээгүй байна гэсэн эцсийн үнэлгээг хийж баталгаажуулсан байгаа.

Энэ заалтууд дээр дийлэнх нь –

- Сангийн яамтай холбоотой,
- Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай холбоотой,
- Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамтай холбоотой,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой,
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай холбоотой –

-ийм 24 заалт хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгсөн байгаа.

Энэ хэрэгжээгүй заалтуудыг нэгдсэн тайлан дээр зохион байгуулалтаас шалтгаалсан гэж үзэж байгаа.

Ингээд өнөөдрийн хуралд холбогдох яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар байна.

Тэгэхээр гишүүний асуулттай холбоотойгоор энэ 24 заалтын хүрээнд Төрийн нарийн бичгийн дарга нар дэлгэрэнгүй тайлбар, мэдээлэл өгөх боломжтой.

Энэ жилийн бидний хяналт, шинжилгээ, үнэлгээний ерөнхий дүн, хэрэгжилтийн хувьд Улсын Их Хурлын бүх Байнгын хороод дээр нэмэгдэж орж ирсэн.

Энэ дээр Засгийн газрын түвшинд зохион байгуулалтын арга хэмжээнүүд авсан. Бид Засгийн газрын түвшинд Улсын Их Хурлын гарсан шийдвэрүүдийн хэрэгжилт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ яам, агентлагийн холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулсан.

Мөн Удирдлагын академитай хамтарч ажилласан. Ингээд хэрэгжилтийн байдлыг бодитой үнэлэх, холбогдох шалтгаан, тайлбар, нөхцөлийг яамдаас хүлээж аваад ажилласан.

Энэ жилийн биелэлтийн хувь нэмэгдэж орж ирсэн үзүүлэлттэй байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар санаачилгатай ажиллаасай гээд хүсэж байгаа.

Би Г.Эрдэнэбат даргад хамтарч ажиллах чиглэлээр ярьсан. Улсын Их Хурлын даргад танилцуулаач ээ гэж байгаа юм.

Тэгэхээр нөгөө “аудитын сэдэв” гэдэг шиг яг Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн заалтуудын хэрэгжилтээсээ гадна яг энэ жилдээ аль аль хуулиудын тайлагнах хугацаа болжээ гэдэг дээр нэгдүгээрт дүгнэдэг.

Хоёрдугаарт, нэмж тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дээрээ ямар хуулиудыг нэмж хэрэгжилтийн үр дагаврыг нь сонсох вэ гэдэг асуудлыг сэдвээ өгөөд энэ дээрээ Засгийн газар жилийн бэлтгэл хийдэг тийм байдал руу ормоор байна.

Жил жилийн өмнө сэдвээ өгөөд баталдаг байхгүй бол энэ тайлагналт ерөөсөө болохгүй байгаа байхгүй юу. Бид хэдийн Улсын Их Хурлын гишүүдийн нүд, чихийг онгойлгох юм чинь энэ тайлан байхгүй юу.

Та хэдийн баталсан хууль чинь угаасаа ийм байна. Болохгүй байна. Эсвэл энэ дээрээ төсөв тавьж өгөөгүй учраас болохгүй байна. Энэ дээрээ эсвэл хүний нөөцийг нь бүрдүүлж өгч орон тоог нь баталж өгөөгүй учраас болохгүй байна гэж бид хэдээс ярих ёстой шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлүүд байна.

Тэгээд хоёрдугаарт, энэ тайлагналтын үг, хэллэгээс эхлээд Үндсэн хуулийн эсрэг утга санаа байж болохгүй. Хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэж орж ирж тайлан дээрээ гэдэг чинь Засгийн газар тэгж тайлагнаж болохгүй шүү дээ.

Тэгэхээр үүнийг ерөөсөө цаашдаа хэлбэрийн хувьд хэдүүлээ Үндсэн хуулийн үзэл санаатай ойлгуулж агуулгын хувьд зөв болгохгүй бол энд ингээд үл ойлголцлууд гарах нь, үр дүнгүй болох нь.

Хоёрдугаарт, Parliament.mn-ийг тэр AI-тай уялдуулаад байгаа, хиймэл оюунтай уяад байгаа юмнуудыг зөв болгохгүй бол түүн дээр чинь зүгээр нэг ийм software, код бичдэг хэдэн залуучууд өөрсдийнхөө хандлагаар бичсэн байгаа байхгүй юу.

Мэдээж энэ хуулиудын эрэмыг зөв тогтоогоод өгвөл зөрчлүүд арилна. Илэрхий зөрчилдөж байгаа юм байвал засаж болно. Жишээ нь, хамгийн энгийн зүйл чинь гаалийн татвараас тухайлан бараа, бүтээгдэхүүнийг чөлөөлөөд нэг удаагийн хууль гарвал энэ чинь тэргүүн ээлжид үйлчилнэ. Текст нь Гаалийн албан татвар болон Гаалийн тарифын тухай хуультай зөрчилдсөн ч гэсэн.

Тэгээд энэ хууль нь асуудлыг зохицуулж чадахгүй бол Татварын ерөнхий хуулиар зохицуулах байхгүй юу. Гаалийн хуулиар. Ийм л зарчмаар ингэж хуулиудын эрэмбэ ингээд явдаг. Одоо Газрын ерөнхий хууль хамгийн сүүлд үйлчилнэ. Үүний өмнө нь Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх хууль ч байдаг юм уу.

Тэгэхээр ингээд эрэмбээ бид ойлгохгүй бол энэ төрд ажиллаж байгаа олон залуучуудыг шийдвэр гаргалаа гэж буруутгал руу оруулаад байна шүү дээ. Төрийн шийдвэрүүдийг чинь эргэж буцаад байна шүү дээ.

Тэгээд энэ төрд чинь энэ эс үйлдэхүй буюу төрийн энэ ажиллаж байгаа хүмүүс чинь шийдвэр гаргахгүй, гаргасан нэгийг нь АТГ дээр байцаагаад байна шүү дээ.

Тэгээд хэдүүлээ үүнийг зөв ойлголтоор ядаж тайлагнаж, үүнийг ойлголтыг өгөхгүй бол ийм байдлаараа бид хэд явахгүй нь.

Тэгээд би энэ асуудлыг маш олон жил ярьж байгаа. Манай хууль зүйн сургуулиуд буюу боловсон хүчин бэлтгэдэг сургуулиуд хүртэл энэ асуудлыг ойлгодоггүй, мэддэггүй, хичээлээ заадаггүй, тэгээд Улсын Их Хурлын Тамгын газар маань үүнийг мэддэггүй. Механикаар санал гаргахдаа энэ хуулийн заалт тэр хуультай зөрчилдөөд байна гээд хүчээр тулгаад ингээд бүх зүйлүүдийг нэг хэмнэлд оруулдаг.

Энэ текстүүд чинь зөрчилдсөн ч гэсэн эрэмбээрээ бүх асуудлууд явах байхгүй юу. Тэгээд ийм байдлаар яваад нийгмийн амьдралыг ерөөсөө нэг голдирол руу оруулаад дуусгалаа. Ялангуяа материаллаг хэм хэмжээг зөрүүлж болохгүй боловч процессын хэмжээ зөрүүтэй байж болдог юм. Онолын түвшиндээ. Тэгээд аль хууль нь эрэмбийн хувьд түрүүлж үйлчлэх вэ гэдгээрээ асуудлаа шийддэг байхгүй юу даа, манайхаан.

Тэгэхээр үүнийг хэдүүлээ нэг өөрчилъе. Тэгэхгүй Та хэд маань ч гэсэн 11 Байнгын хороогоор яваад л, Улсын Их Хурлын юу маань ингээд нэг ойлгомжгүй яваад л. Ийм зүйлүүд байна.

Тэгээд үүнийг Хэрэг эрхлэх газрын дарга бас нэг анхаараад ажлын хэсэг дээр ямар хүмүүс өгөх вэ? Та өөрөө орох уу? Эсвэл би өөрөө энэ С.Бямбацогт даргад хэлж байгаад нэг ажлын хэсэг гаргаад ямархуу байдлаар үүнийг үр дүнтэй болгох уу гэдэг асуудлыг нэг яримаар байна.

Тэгээд хэн хэнийхээ ажлыг уяхгүйгээр тэгэхдээ үр дүнтэй, дээрээс нь Үндсэн хуулийнхаа агуулга, үзэл санаандаа байхгүй бол одоо манай Хэрэг эрхлэх газрын тайлан анзаараагүй л байна л даа. Хоёр сайдын дунд байгаа.

Энэ тогтоолыг чинь хэрэгжүүлэх боломжгүй... /минут дуусав/

Н.Наранбаатар: Би нэг товч үг хэлье.

Засгийн газрын тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг танилцуулж байгаа, хэлэлцүүлж байгаа байдал чинь нэг л биш байгаа юм.

Яагаад гэхээр П.Сайнзориг гишүүн бид хоёроос бусад гишүүд гараад явчхаж байгаа юм.

Тэгэхээр гишүүд чинь ач холбогдол өгөхгүй байгаа байхгүй юу. Урьд жилүүд ингээд л явсан л нэг ийм форматаар л яваад.

Тэгээд бусад Байнгын хороодоор ингээд л явах юм. Цаг үрэх юм. Ингээд л 20, 30 хүн явах юм. Тэгээд л гол Төрийн нарийн бичгийн дарга нар энд ирээд суух юм. Тэгээд хэдэн өдөр ч явдаг юм. Мэдэхгүй.

Тэгээд нэг ийм зузаан бичиг хэрэг зардлаасаа өгсүүлээд л харахад нэг ийм. Тэгээд ойлгомжгүй юм. Дараа жил жоохон өөрчлөх гээд үзэх үү. Арай өөр. Хэлэлцүүлэг. Энэ чинь ядаж нэг амьтай. Тэгээд ямар ч юу байхгүй чив чимээгүй сууж байгаад нэг тайлан хэлэлцүүлсэн ч биш, нэг ээлж өнгөрөөсөн маягийн л юм болоод байх юм. Арай өөрчлөх боломж байдаг юм уу, үгүй юм уу. Зүгээр судалж үзээрэй. Нэг тийм амьтай, асуулттай, хариулттай, дүгнэлттэй нэг ийм юм байхгүй бол энэ чинь нэг олон мэргэжилтнүүдээс шахаж байгаад л баахан цаасууд. Сумаас эхлээд л дээш нь аваад л. Тэгээд л энд нэг албан тушаалтан нийлүүлж бариад л маш олон хүн цаашаагаа 330 сумаас авч байгаа. Аягүй бол мянга хэдэн багийн дарга нараас авч байгаад л тэгээд бичиг цаас, цаг хугацаа, зардал чирэгдэл гээд л. Тэгээд энд ирээд л бид ч гэсэн ингээд нэг ийм уйтгартай ийм юманд суугаад баймааргүй л байгаа.

Тэгээд үүнийгээ өөрчлөөрэй л гэж хэлье. Анхаарна биз ээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх цаашдаа анхаарна биз.

Засгийн газраас ирүүлсэн Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

Гишүүд хамтарсан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо хамтарсан хурал “Жанжин Д.Сүхбаатар” танхимд шууд үргэлжилнэ.

Гишүүдийг тийшээ орохыг хүсэж байна.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 13 цаг 23 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД